

Пентатух

10-р Хичээл

Иосеф болон Түүний ах нар

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

© 2014 Гуравдахь мянган жил үйлчлэл

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Библийн бүх эшлэлийг Ариун Библи 2019 (АБ2019), Ариун Бичээс Нийгэмлэг.

ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ

ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛ нь 1997 ОНД ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН, АШГИЙН БУС, ХРИСТИТГЭЛИЙН САЙНМЭДЭЭНИЙ ҮЙЛЧЛЭЛ БӨГӨӨД ДАРААХ ТАЛБАРУУДАД ЧИГЛЭДЭГ:

БИБЛИЙН БОЛОВСРОЛЫГ, БҮХ ДЭЛХИЙД, ҮНЭГҮЙГҮЙГЭЭР.

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, дахин давтагдашгүй, цуврал хичээлүүдийг Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчлэлүүдээр маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг. Эдгээр нь сургууль, бүлгүүд, хувь хүмүүс танхимаар болон цахимаар ашиглахад зориулагдсан болно.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловсруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид теологийн мэргэжлийн сургагч багш нар байдаг бөгөөд орчуулагчид нь орон нутгийнхаа унаган хэлтэй теологийн мэдлэгтэй хүмүүс байдгаараа давуу талтай. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд Гурав дахь мянган үйлчлэл нь сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл <https://www.thirdmill.org> цахим хуудсаар зочлоорой.

Агуулга

УДИРТГАЛ	1
БҮТЭЦ БА АГУУЛГА	2
Эцгүүдийн эв нэгдэлгүй байдал (Эхлэл 37:2-36).....	3
Иосеф ах нарынхаа дургүйг хүргэсэн нь	3
Ах нар нь Иосефыг зарсан нь	4
Иосефыг удирдагч болоход нь заналхийлсэн нь (Эхлэл 38:1–41:57)	4
Канаан дахь Иудагийн гэм нүгэл (Эхлэл 38:1-30)	5
Египет дэх Иосефын амжилт (Эхлэл 39:1–41:57)	6
Эвлэрч, дахин нэгдсэн нь (Эхлэл 42:1–47:12).....	7
Эхний аялал (Эхлэл 42:1-38).....	7
Хоёр дахь аялал (Эхлэл 43:1–45:28).....	7
Гурав дахь аялал (Эхлэл 46:1–47:12)	9
Иосефын энэрэнгүй захиргаа (Эхлэл 47:13-27)	9
Эцгүүдийн эв нэгдэл (Эхлэл 47:28–50:26)	10
Иаковын гэр бүлийн зохион байгуулалт (Эхлэл 47:28–50:14)	10
Иосефын гэр бүлийн зохион байгуулалт (Эхлэл 50:15-26)	11
ҮНДСЭН СЭДВҮҮД	12
Нийтлэг шинжүүд.....	13
Бурханы Израилд өгсөн нигүүлсэл	13
Бурханд үнэнч Израил	14
Бурханы Израилд өгсөн ерөөл	15
Бурханы Израилаар дамжуулан өгдөг ерөөл.....	15
Онцлог шинжүүд	16
Үндэстний эв нэгдэл	17
Үндэстний ялгаа.....	20
ДҮГНЭЛТ	23
ХАМТРАГЧИД	25
ҮГСИЙН ТАЙЛБАР	26

Пентатух

Аравдугаар хичээл

Иосеф ба түүний ах дүүс

УДИРТГАЛ

Залгамжлах өв хөрөнгө ихтэй айлын ах, эгч дүүс хэн нь хамгийн их өв өвлөж авах вэ гэж хоорондоо маргалдах явдал их гардаг. Нэг үеийнхэн хойч үедээ өв залгамжлуулах цаг ирэхэд бие биеэ чин сэтгэлээсээ хайрлаж байсан ах эгч дүүс ч гэсэн зөвхөн Бурхан л хайрын хэлхээ холбоог нь сэргээж чадахаар тийм ноцтой муудалцаж, хагарч хуваагдаж болно. Израил үндэстний өвөг эцгийн гэр бүлд буюу Иосеф болон түүний ах дүү нарын дунд ч гэсэн яг ийм нөхцөл байдал үүссэн гэдгийг Эхлэл номоос бид харж болно. Эцэг Иаковынхаа өв хөрөнгийн төлөөх ах дүүсийн өрсөлдөөн маш ширүүн байсан тул энэ асуудлыг шийдвэрлэх боломжгүй мэт санагддаг. Гэхдээ Бурхан Иосеф болон түүний ах нарыг эвлэрүүлж, хайрын холбоог нь сэргээсэн гэдгийг бид энэ хичээлээс үзэх болно. Энэхүү эвлэрэл нь Хуучин Гэрээний туршид Израилын арван хоёр овог аймгийн хоорондох харилцааг чиглүүлж байв. Мөн энэ сургамж өнөөг хүртэл Христийн дагалдагчдын харилцааг ч удирдан чиглүүлсээр байна.

“Пентатух” цувралын энэ хичээлээр Эхлэл ном дахь “Иосеф болон түүний ах нарын” түүхийг судлах болно. Бид Эхлэл 37:2–50:26-р хэсгээс Иосефын ах нартайгаа харилцах төвөгтэй харилцааны талаар нарийвчлан үзнэ.

Үндсэн сэдэв рүүгээ орохоос өмнө Эхлэл номын гол агуулгыг эргэн харах нь тустай байх болов уу. Өөр нэг хичээл дээр бид Эхлэл номыг гурван үндсэн хэсэгт хуваадаг гэдгийг үзсэн. Хэсэг тус бүр нь Мосегийн анхны Израил уншигчдад тодорхой арга замаар хүрэх зорилготой байв. Эхний хэсэгт буюу Эхлэл 1:1-11:9-д өнө эртний түүхийг өгүүлдэг. Энэ хэсэгт Мосе Израилчуудыг Канаан нутаг руу дуудсан нь дэлхийн түүхийн эхэн үед Бурханы хийсэн зүйлтэй холбоотой гэдгийг харуулжээ. Хоёр дахь хэсэгт буюу Эхлэл 11:10-37:1-д эцгүүдийн эртний түүхийг тэмдэглэсэн байдаг. Мосе энд Абрахам, Исаак, Иаков нарын амьдралыг Амласан газар руу явах замдаа Израилчуудад тулгарч байсан бэрхшээлүүдтэй холбон ярьсан. Гурав дахь хэсэг болох Эхлэл 37:2-50:26-д эцгүүдийн хожуу үеийн түүх буюу Иосеф болон түүний ах нарын түүх гардаг. Тус хичээлээр Эхлэл номын сүүлчийн энэ хэсэгт анхаарлаа хандуулах болно.

Мосе Эхлэл номын энэ хэсгийг бичихдээ анхны сонсогчдодоо хэд хэдэн зүйл заах зорилготой байсан гэдгийг бид үзэх болно. Гэхдээ ерөнхийдөө:

Иосеф болон түүний ах нарын түүх нь Амласан газрыг эзлэн авч, суурьших үедээ хэрхэн эв найртай амьдрах учиртайг Израилын овгуудад заадаг гэж хэлж болно.

Иосеф болон түүний ах нарын талаарх энэ хичээл хоёр хэсгээс бүрддэг. Эхлээд бид эдгээр бүлгийн бүтэц, агуулгыг, мөн эдгээрийн утга зохиолын загвар болон сэдвүүд хоорондоо хэрхэн нийцэж байгааг үзнэ. Хоёрдугаарт, бид Мосегийн Израилын овог аймгуудад зориулж онцлон өгүүлсэн зарим гол сэдвийг болон эдгээр

сэдэв нь орчин үеийн Христитгэгчидтэй ямар холбоотой болохыг авч үзэх болно. Ингээд эхлээд Эхлэл номын энэ хэсгийн бүтэц, агуулгыг харцгаая.

БҮТЭЦ БА АГУУЛГА

Иосеф болон түүний ах нарын түүхийг мэддэг хүн бүр энэ түүхэнд олон хүн, олон ялгаатай соёл, ээдрээтэй үйл явдлууд гардаг гэдгийг мэддэг. Эдгээр шинж чанар нь маш нарийн төвөгтэй байдаг учир нарийн ширийн зүйлд баригдаад, энэ бүгдийг холбож байгаа утга зохиолын чухал бүтцийг амархан орхигдуулах хандлага гаргадаг. Гэхдээ Иосеф болон түүний ах нарын түүх бол нэгдмэл нэг жүжиг шиг учраас эдгээр бүлгийн бүтэц, агуулга хэрхэн уялдаж байгааг анхаарах нь маш чухал юм.

Мосе Эхлэл 37:2-50:26-д таван үе шаттай маш нарийн уялдаа холбоо бүхий нэгэн жүжгийг хүүрнэн өгүүлж байна:

- Түүхийн эхний асуудлыг буюу Иосеф ирээдүйд удирдагч болж болзошгүй байгаа нь ах дүүсийг хагарахад хүргэсэн тухай Эхлэл 37:2-36-д дүрслэн өгүүлжээ.
- Хоёрдугаар үе болох 38:1-41:57 нь Иосефыг удирдагч болоход заналхийлсэн үйл явдлаас, түүний Египетэд эрх мэдэлтэй нэгэн болох хүртэлх түүхийг голлон өгүүлдэг.
- Гуравдугаар үе буюу 42:1-47:12 нь жүжгийн оргил хэсэг, эргэлтийн үе юм. Энэ нь Египетэд эцгүүд хэрхэн эвлэрч, дахин нэгдэж байгаа тухай өгүүлдэг.
- Дөрөвдүгээр үе болох 47:13-27 нь жүжгийн бууралт хэсэг бөгөөд Иосеф Египетийг хэрхэн энэрэнгүй агаад мэргэн ухаанаар удирдаж байгааг өгүүлдэг.
- Жүжгийн эцсийн дүгнэлт 47:28-50:26-д гарах агаад энд Иосефын удирдлага дор эцгүүд эвлэлдэн нэгдсэн тухай дүрсэлсэн байдаг.

Сүүлийн хэдэн арван жилд Библи судлаач, тайлбарлагч нар Эхлэл номын эдгээр бүлэг нь Хиазм хэлбэрээр бичигдсэн гэж үзэх болсон. Хиазм гэдэг нь:

Түүхийн гол хэсгийн өмнөх болон дараах хэсгүүд нь хоорондоо зэрэгцээ буюу тэнцвэртэй байдаг уран зохиолын бүтцийг хэлдэг.

Эдгээр оролдлогын ихэнх нь тус үзлийг хэт их онцолсон байдаг. Гэхдээ энэ нь Иосеф болон түүний ах нарын тухай түүх нь бүхэлдээ томоохон хэмжээний, тэгш хэм бүхий жүжгийн хэлбэрээр бичигдсэн түүх болохыг харуулж байна.

Ерөнхийдөө энэ түүх эцгүүдийн эв нэгдэлгүй байдлаар эхэлсэн ч эцэст нь тэд эвлэн нэгдсэн гэдгийг илэрхийлж байгааг олж харахад тийм ч хэцүү биш. Иосефыг удирдагч болоход заналхийлж буй Египетэд болсон үйл явдлуудын өрнөл хэсгийг Египет дэх түүний энэрэнгүй, мэргэн удирдлагын тухай өгүүлдэг бууралт хэсэгтэй харьцуулж болно. Мөн Египетэд ах дүү нар уулзаж, эвлэрсэн, дахин нэгдсэн үйл явдал нь эв нэгдэлгүй байдал, аюул заналхийллээс өршөөл, эв нэгдэлд хүрэх эргэлтийн цэг буюу оргил хэсэг нь болдог. Эдгээр үйл явдлыг бид Мосегийн

танилцуулсан дарааллаар авч үзнэ. Гэхдээ Иосеф болон түүний ах нарын түүхийн талаар олон нарийн ширийн зүйлийг судлахдаа энэхүү тэгш хэмийг ойлгож байх нь бидэнд ихээхэн тус болох болно.

Иосеф болон түүний ах нарын түүх нь Эхлэл номын бусад хэсгээс утга зохиолын хувьд илүү нарийн төвөгтэй байдлаар бичигдсэн. Энд олон янзын дүр гардаг төдийгүй олонх нь гүн гүнзгий утга агуулга бүхий, хувьсан өөрчлөгддөг дүр байдаг. Мөн энэ түүхийн үзэгдлүүд маш тод томруун дүрслэгдсэн бөгөөд түүхийн туршид егөөдөл, хошигнол, эмгэнэлт явдал олон гардаг. Уг хүүрнэлд бусад үйл явдлыг эргэн санах, урьдчилан таамаглах боломжтой олон гэнэтийн эргэлтийг багтаасан байдаг. Үнэндээ анхны Израил сонсогчид нь Эхлэл номын энэ хэсгээс бидэнтэй харьцуулахад хамаагүй олон зүйлийг сурч, мэдэх шаардлагатай байв. Тиймээс цаг хугацаа хэмнэх үүднээс бид бүлэг бүрийн агуулгын талаар зөвхөн цөөн хэдэн тайлбар хийх болно.

ЭЦГҮҮДИЙН ЭВ НЭГДЭЛГҮЙ БАЙДАЛ (ЭХЛЭЛ 37:2-36)

Мосе Эхлэл 37:2-36 дэх хүүрнэлээ Иосеф ирээдүйд удирдагч болохтой холбоотой эцгүүдийн эв нэгдэлгүй байдлыг харуулсан түүхээс эхэлдэг. Энэ эхний бүлэг нь хоёр хэсгээс бүрддэг бөгөөд Иосефын гэр бүлийн эв түнжин цаг хугацааны явцад хэрхэн муудаж байгааг харуулдаг. Эхний хэсэг болох 37:2–11 нь Иосеф хэрхэн ах нарынхаа дургүйг улам их хүргэж байгааг харуулж байна. Хоёр дахь хэсэг болох 12-36-р эшлэлд ах нар нь Иосефыг хэрхэн боол болгон худалдсан тухай өгүүлдэг. Тэгвэл Иосеф ах нарынхаа дургүйг хэрхэн хүргэж байсныг харцгаая.

Иосеф ах нарынхаа дургүйг хүргэсэн нь

Мосе эхэндээ Иосефыг эцгийнхээ таалалд нийцсэн гэм зэмгүй залуу гэж дүрсэлсэн байдаг. Жишээ нь, 3-р эшлэлд Иаков Иосефт гоёмсог дээл хийж өгч, ах нарынх нь атаархлыг төрүүлсэн тухай өгүүлдэг. Мөн 4-р эшлэлд “Ах нар нь ... Иосефыг үзэн ядаж, түүнтэй эв найртай ярилцаж чаддаггүй байжээ” гэсэн байна. Үүний дараа Иосеф ирээдүйд гэр бүлийнхнээ захирах болно гэсэн утгатай хоёр зүүдээ сайрхан ярьсан нь нөхцөл байдлыг улам дордуулдаг. Үүнээс болж Иосефын ах нар "түүнийг улам илүү үзэн ядах болсон" гэдгийг Мосе 5 ба 8-р эшлэлд бичжээ. Мөн 11-р эшлэлд "Ах нар нь түүнд атаархсан" гэж хэлсэн байдаг.

Иосеф болон түүний ах нарын хоорондох зөрчилдөөний шалтгаанаас би хоёрыг нь сонгож яримаар байна. Нэгд, аав нь түүнд хамгийн гоё дээл хийж өгөхөд бусад ах нь түүний хувцсыг хараад "Өө, би ч гэсэн ийм дээлтэй болмоор байна. Энэ дээл минийх байх ёстой" гэж байсан байх. Бид ч гэсэн өөрсдийгөө хараад, зарим хүн биднээс илүү сайхан амьдарч байгаатай харьцуулж, “Би яагаад бусадтай адилхан биш байгаа юм бэ?” гэж асуудаг шүү дээ. Ийм хандлага хүмүүсийн дунд хагарал, эв нэгдэлгүй байдлыг авчирдаг болохыг өнөөгийн нийгмээс ч харж

болно. Чуулган дотор ч гэсэн ийм эв нэгдэлгүй байдал гардаг. Мөн бид өвчтэй байх үедээ, эрүүл хүмүүсийг хараад “Би яагаад эрүүл биш байгаа юм бэ?” гэж өөрөөсөө асуудаг. Тиймээс Иаков зөвхөн Иосефт л хамгийн сайныг өгөөд, бусдад нь өгөөгүй учраас ах дүүсийн хооронд эв нэгдэлгүй байдал бий болсон. Хоёр дахь нь, хүний мөн чанар муудсанаас үүдэлтэй. Дүү нь өөрсдөөс нь илүү сайхан хувцас өмсөж, гоё харагдаж байсан тул ах нар нь түүнд атаархах болжээ. Атаархлын үрийг бид хүн бүрээс олж харж болно. Энэ үр зөвхөн Иосефын ах нарт биш, бас бидэнд бүгдэд нь байдаг юм. Гэхдээ Христитгэгчид бид эхлээд үүнийг таньж, атаархал нь гэм нүгэл гэдгийг мэдэж, үүнийг таслан зогсоохоор дуудагдсан билээ.

— Пастор Др. Киприан К. Гучиенда

Иосеф ах нарынхаа дургүйг хүргэснээс болж эцгүүдийн хооронд эв нэгдэлгүй байдал бий болсныг өгүүлснийхээ дараа Мосе 37:12-36 дээрх хоёрдугаар хэсэг рүү шилжиж байна. Эдгээр эшлэлд ах нар нь Иосефыг хэрхэн боол болгон худалдсан тухай товч хүүрнэл гардаг.

Ах нар нь Иосефыг зарсан нь

Ах нар нь Иосефыг барьж аваад, гоёмсог эрэн дээлийг нь тайлж, алахаар төлөвлөж байгааг эндээс харж болно. Хамгийн том ах Реубен нь Иосефыг зугтахад туслах гэж оролдсон боловч чадаагүй. Гэвч эцэст нь Иуда бусад ах дүү нараа ятгаж, Иосефыг алахаас илүү боол болгож зарсан нь дээр гэж ятгажээ. Иосефын ах нар түүнийг зэрлэг амьтанд идүүлсэн гэж Иаковт эмгэнэлтэй бөгөөд худал мэдээ хүргэж байгаагаар уг хэсэг өндөрлөдөг. Ах нар нь Иосефын цусанд будагдсан дээлийг эцэг Иаковт нь өгсөн бөгөөд тэрээр асар их гашуудан, тайвшрахаас татгалздаг.

Энэ хоёр түүх хамтдаа Иосеф болон түүний ах нарын түүхийг бүхэлд нь тодорхойлох нэгэн гол асуудлыг харуулж байна. Энэ нь Израилын овгуудын эцгүүдийн хоорондох эв нэгдэлгүй байдлын эхлэл байв.

Ийнхүү Иосеф ирээдүйд удирдагч болохтой холбоотой ах дүүсийн дунд хагарал гарсан бөгөөд Мосе үүнээс үүдэлтэй эхний асуудлыг өгүүлснийхээ дараа хоёр дахь алхам руу шилжиж байна. Тэрээр 38:1-41:57-д Иосефын удирдагч болох боломж илүү аюултай байдалд орж байгаа тухай өгүүлдэг.

ИОСЕФЫГ УДИРДАГЧ БОЛОХОД ЗАНАЛХИЙЛСЭН НЬ (ЭХЛЭЛ 38:1–41:57)

Энэ үе шатанд Мосе сонсогчдодоо гол дүрүүдийн талаарх ойлголтыг өгөхийн тулд нэгэн гайхалтай егөөдлийг ашигладаг. Нэгдүгээрт, Иудагаар төлөөлүүлсэн Иосефын ах нар нь Канаан нутагт амьдарч байсан бөгөөд тэд Иосефыг өөрсдөөс нь илүү байр суурь эзлэхэд саад болж чадсан гэдэгтээ итгэлтэй байсан бололтой. Гэвч

тэднийг мэдээгүй байхад Египетэд Иосефын засаглал бэхжиж байв. Бурхан Иосефын боолын амьдралыг гэр бүлээс нь илүү өндөр байр сууринд хүргэх зам болгон хувиргажээ.

Иосефыг удирдагч болоход заналхийлсэн түүхийг хоёр гол хэсэгт хуваан авч үзэх болно. Эхлээд 38:1-30-д Канаан дахь Тамарын эсрэг Иудагийн нүглийн тухай, дараа нь 39:1-41:57 дээрх Иосефын Египет дэх амжилтын талаар хамт үзнэ. Ингээд Канаан нутагт байхдаа Иудагийн үйлдсэн нүглийн талаар хамтдаа харцгаая.

Канаан дахь Иудагийн гэм нүгэл (Эхлэл 38:1-30)

Иуда энэ бүлгийн гол дүр болж орж ирэх болсон шалтгаан нь өмнөх хэсэгт ах дүүс нийлж Иосефыг алахаас Реубен биш, харин Иуда сэргийлж чадсантай холбоотой юм. Тиймээс энэ бүлэг нь ах дүүсийнхээ дунд хамгийн өндөр байр суурийг эзэлсэн Иаковын хүү Иудагийн үйлдлийг харуулдаг. Канаан дахь Иудагийн үйлдсэн гэмт үйл явдал 38:1-5-д Иудагийн хөвгүүдийн мэндэлсэн тухай мэдээгээр эхэлдэг. 2-р эшлэлд Иуда канаан эмэгтэйтэй гэрлэсэн гэдгийг хэлсэн нь ёс суртахууны өнгө аясыг харуулж байна.

6-11-р эшлэлд Иудагийн хөвгүүд болон Тамарын тухай өгүүлдэг. Эхлээд Иуда Тамарыг ууган хүү Ердээ эхнэр болгон өгчээ. Ер нас барах үед Иуда Тамарыг хоёр дахь хүү Онанд өгөв. Дэд хууль 25:5-10-д хүргэн дүү нь ахынхаа хүүхэдгүй бэлэвсэн эхнэртэй гэрлэх тухай гэрлэлтийн хууль гардаг. Энэ заншил нь нас барсан ахыг нь залгамжлах үр удам үлдээх, мөн бэлэвсэн эхнэрийг нь хамгаалах зорилготой байв. Гэтэл Онан Тамарыг хүүхэдтэй болгохоос татгалзаж байгаа тухай 9-р эшлэлд өгүүлдэг. Тиймээс 10-р эшлэлд Бурхан Онаны амийг бас авсан гэжээ. Гурав дахь хүү болох залуу Шела ч гэсэн ах нартайгаа адилхан хувь тавилантай тулгарах вий гэж Иуда айж байв. Тиймээс хүүгээ Тамартай гэрлэхийг зөвшөөрөлгүй, Тамарыг эцгийнх нь гэр рүү буцааж, ичгүүртэй байдалд оруулжээ.

Тамар Иудаг уруу татсан түүхийг 12-26-р эшлэлд өгүүлдэг. Тамар Шелатай гэрлэж чадахгүйгээ ойлгоод биеэ үнэлэгчийн дүрд хувиран, Иудаг уруу татжээ. Тамар Иудаг залилаад зогсохгүй, амласан төлбөрийнх нь барьцаа болгож, Иудагийн тамга, оосор, таягийг нь авч үлдсэн байна. Гурван сарын дараа (24-26-р эшлэл) Тамарыг жирэмсэн болсныг Иуда сонсоод уурлаж, түүнийг цаазлахыг шаарджээ. Гэвч Тамар Иудагийн өгсөн тамга, оосор, таягийг гаргаж өгөх үед Иуда юу хийснээ ухаарч, гэм нүглээ хүлээн зөвшөөрдөг. Эхлэл 38:26-д хэлсэн Иудагийн үгийг сонсоцгооё. Энд:

“Би түүнд өөрийн хүү Шелаг өгөөгүй тул тэр надаас илүү зөв юм байна гэж хэлэв” гэжээ (Эхлэл 38:26).

Өөрийнх нь хийсэн нүгэл Тамарынхаас хамаагүй дор байсныг Иуда хүлээн зөвшөөрсөн гэсэн санааг энэ эшлэл илэрхийлж байна. Мөн тэрээр даруугаар гэм нүглээ хүлээн зөвшөөрч гэмшин, гэмшлийн үлгэр жишээг харуулсан. Энэхүү зүрх сэтгэлийн өөрчлөлтийн улмаас Тамарын эсрэг хийсэн Иудагийн нүглийн түүх эерэг төгсгөлөөр өндөрлөж байна. Мосе энэ хэсгийг Тамар Иудагийн хөвгүүдийг төрүүлсэн тухай мэдээгээр төгсгөж байгаа нь (27-30-р эшлэл) Канаан эмэгтэйн

төрүүлсэн Иудагийн хөвгүүдийн тухай эхний хэсэгтэй харьцуулсан харьцуулалт болдог. Перез, Зера хоёр хоёулаа Иуда овгийн нэр хүндтэй хүмүүс болсон юм.

Канаан дахь Иудагийн гэм нүгэлтэй холбоотой үйл явдлын зэрэгцээ Иосефыг удирдагч болоход заналхийлсэн түүхийн хоёр дахь хэсгийг харцгаая. Эхлэл 39:1-41:57 дээрх энэ хэсэгт Иосеф Египетэд хэрхэн амжилтад хүрсэн тухай нэлээн урт түүхийг өгүүлдэг.

Египет дэх Иосефын амжилт (Эхлэл 39:1–41:57)

Энэ хэсэг нь гурван дэд хэсгээс бүрддэг. Эхний дэд хэсэг болох 39:1-23-т Иосеф Потифарын гэрээс шоронд хоригдох хүртэлх түүхийг өгүүлдэг. Иосеф Египетэд очсон даруйдаа Потифарын тааллыг олж, гэр орных нь бүх зүйлийг харгалзах болжээ. Гэвч Потифарын эхнэр Иосефыг уруу татах гэж оролдох болсон бөгөөд энэ санаа нь бүтэлгүйтэх үед Иосефыг өөрийг нь хүчирхийлэх гэж оролдсон гэж гүтгэдэг. Хэдийгээр Иосеф эхнэрийнх нь үгийг няцаасан боловч Потифар эхнэрийнхээ худал гүтгэлэгт итгэж, Иосефыг Фараоны шоронд хорьжээ. Гэвч Иосеф удалгүй шоронгийн даргын итгэлийг олж авдаг. Энэ хэсэг Иудагийн Тамарын эсрэг үйлдсэн нүглийн тухай хүүрнэлийн яг ард орж ирж байгаа нь Иудагийн тухайн үеийн садар самууныг Иосефын ёс суртахууны цэвэр ариун байдалтай харьцуулан харуулж байгаа хэрэг юм.

Иуда, Тамар хоёрын түүхийг унших үедээ би энэ түүхийн зарим хэсгийг хасаж, засаж янзалмаар, эсвэл өөр газар оруулмаар санагддаг. Гэхдээ хэрэв та хам сэдвийг нь үнэхээр ойлгож уншвал, Бурхан Иосефын тухай аль хэдийнээ өгүүлээд эхэлсэн түүхийнхээ дундуур энэ түүхийг яагаад нэмснийг ойлгох болно. Бурхан зөвт болон зөвт бус хүмүүсийн хоорондох ялгааг харуулахыг хүссэн учраас л ингэсэн гэж би бодож байна. Иосеф Потифарын эхнэрийн бэлгийн ёс бус уруу таталтыг хүчтэй эсэргүүцдэг. Гэтэл Иуда биеэ үнэлэгч авахад, тэр ч байтугай сүмийн янхныг худалдаж авахад ч бэлэн байв. Та ч бас энэ ялгааг харж байгаа байх. Тийм ч учраас Иосеф ууган хүү биш боловч гэр бүлээ зөвийн замд хөтөлж байсан тул Бурхан түүнд ууган хүүгийн хоёр дахин их ерөөлийг өгсөн юм.

— Др. Стефен Ж. Брамер

Хоёрдугаарт, 40:1-41:45-д Иосеф шоронгоос Фараоны ордонд очсон түүхийг өгүүлдэг. Иосеф Фараоны зарц нарын зүүдний утга учрыг тайлснаар хэрхэн эрх мэдэлд хүрснийг Мосе энэ хэсэгт тайлбарлажээ. Дараа нь тэрээр өнөтэй сайхан долоон жил болон өлсгөлөнгийн долоон жилийн тухай Фараоны зүүдийг тайлж өгдөг.

Гурав дахь дэд хэсэгт буюу 41:46-57-д Мосе Фараоны ордонд Иосефын засаглал хэрхэн тогтсон тухай товч өгүүлж байна. Мосе энэ хэсэгт Иосеф Египетэд Фараоны дараа хоёрт орох эрх мэдэлтэй байсан гэдгийг хэд хэдэн байдлаар харуулжээ. Иосефыг амжилт гаргах болгонд тэр өөрийн ухаанаар бус харин Бурханы

оролцоо, тусламж байсан учраас ийм эрх мэдэлд хүрсэн гэдгийг Мосе тодорхой хэлсэн байдаг.

Одоогоор бид Иосефыг ирээдүйн удирдагч болохтой холбоотой эцгүүдийн эв нэгдэлгүй байдлыг болон Египетэд түүнийг удирдагч болоход заналхийлж байсан үйл явдлууд, түүний амжилт зэргийг үзээд байна. Харин одоо Эхлэл 42:1-47:12-д бичигдсэн эцгүүдийн эвлэрэл, дахин нэгдсэн түүхийг буюу үндсэн түүхийнхээ эргэлтийн цэг рүү очицгооё.

ЭВЛЭРЧ, ДАХИН НЭГДСЭН НЬ (ЭХЛЭЛ 42:1–47:12)

Эвлэрч, дахин нэгдсэн тухай энэхүү гол хүүрнэл нь Иосефын гэр бүлийн Канаанаас Египет хүртэл хийсэн хоорондоо нягт холбоо бүхий гурван аяллаас бүрддэг. Эхний аялал Эхлэл 42:1-38-д гардаг. Хоёр дахь аяллыг 43:1-45:28-аас харж болно. Гурав дахь аяллын тухай 46:1-47:12-д өгүүлсэн байдаг. Одоо эхний аяллыг харцгаая.

Эхний аялал (Эхлэл 42:1-38)

Эхний аялал нь гурван аяллын түүхийн хамгийн энгийн нь бөгөөд үүнийг гурван хэсэгт хувааж болно. Эхлээд 42:1-5-д ах дүүс их өлсгөлөнгийн улмаас Канаанаас Египет рүү аялжээ. Энэ хэсэгт Иаков Бениаминаас бусад Иосефын бүх ахыг Египетээс хоол хүнс худалдаж авхуулахаар илгээдэг.

Хоёр дахь хэсэг болох 42:6-28-д Египетэд Иосеф анх удаа ах нараа харж, тэднийг таньсан тухай үйл явдлыг өгүүлдэг. Гэвч тэр өөрийгөө хэн гэдгийг таниулаагүй агаад ах нарынхаа хүн чанарыг шалгахын тулд Бениаминыг авчрахыг шаардаад, тэднийг буцааж Канаан руу явуулжээ. Эхлээд Иосеф Бениаминыг авчрах хүртэл ах дүүсийн нэгээс бусдыг нь Египетэд шоронд хорино гэж сүрдүүлсэн. Үүний үр дүнд ах нар нь өөрсөд дээрээ шүүлтийн цаг ирснийг ойлгож эхлэв. 42:21-д тэд өөр хоорондоо “Бид дүүгийнхээ явдлаас болж ялтан болцгоолоо” гэлцэж байлаа. Гурав хоногийн дараа Иосеф Симеоноос бусад бүх ах нараа гэр рүү нь буцааж, Бениаминыг авчрахыг тушаав. Тэр тэдний уутыг үр тариагаар дүүргээд зогсохгүй, үр тариа худалдаж авахаар авчирсан мөнгийг нь буцааж уутанд нь хийхийг тушаажээ. Ах дүүс буцаж явах замд тэдний нэг нь уутанд мөнгө нь байхыг хараад бусдадаа хэлдэг. Тэд ихэд айж, “Бурхан бидэнд юу хийх нь энэ вэ?” (28-р эшлэл) гэгцгээдэг.

Гурав дахь хэсэг болох 29-38-р эшлэлд ах дүүс Канаан руу буцаж ирээд, өөрсөд нь юу тохиолдсоныг өгүүлдэг. Тэд Бениаминыг өөрсөдтэй нь хамт Египет рүү буцаан явуулах талаар эцгээ ятгах гэж оролдсон боловч Иаков татгалздаг. Тиймээс ах дүүс Канаан нутагт үлдэв.

Хоёр дахь аялал (Эхлэл 43:1–45:28)

Бид эхний аяллын талаар товч үзээд байна. Харин одоо Эхлэл 43:1-45:28-д гардаг хоёр дахь аяллын үйл явдлуудыг харцгаая. Хоёр дахь аялал нь мөн гурван үндсэн хэсгээс бүрддэг бөгөөд эхний аяллаас арай илүү олон үйл явдал өрнөдөг. Эхний хэсэг болох 43:1-14-р эшлэл нь ах дүүс Египет рүү аялахаас өмнөх үйл явдлыг өгүүлдэг. Хоол хүнс нь дууссаны эцэст Иаков Бениаминыг ах нарынх нь хамт Египет рүү явуулахаас өөр аргагүй болжээ.

43:15-45:24 дээрх хоёр дахь хэсэг нь Египетэд болсон үйл явдлуудын талаар дэлгэрэнгүй өгүүлдэг. Эхлээд 43:15-34-д Иосеф гэртээ том найр хийж, ах дүү нараа угтан авсан. Гэхдээ тэр өөрийгөө хэн болохыг нууцалсан хэвээр байв. Иосеф Бениаминыг хараад сэтгэл нь их хөдөлсөн тул өрөөнөөсөө гарч ганцаараа уйлсан гэдгийг 43:30-д бичсэн байдаг.

44:1-13-д Иосеф ах нараа дахин сорьжээ. Тэрээр гэрийн даамалдаа ах дүү нарынхаа шуудайг үр тариа, мөнгөөр дүүргээд, Бениамины уутанд мөнгөн аяга хийхийг тушаав. Тэгээд Иосеф ах дүү нараа Канаан уруу буцаан явуулжээ. Гэвч Иосефын тушаалаар гэрийн даамал нь ах дүү нарынх нь араас гүйцэж очдог. Тэр Бениамины шуудайнаас мөнгөн аягыг “олж”, тийнхүү ах дүү нарыг Иосефын гэрт буцаан авчирав.

14-34-р эшлэлд Иуда Иосефоос өршөөл үзүүлэхийг гуйж, 16-р эшлэлд “Таны зарц нарын хилэнцийг Бурхан олсон” хэмээн буруугаа хүлээн зөвшөөрсөн байдаг. Дараа нь Иуда Бениамины оронд Египетэд үлдэхийг гуйдаг бөгөөд Иудагийн чин сэтгэлийн энэ гуйлт Иосефын сэтгэлийг ихэд хөдөлгөжээ. Эцэст нь 45:1-15-д Иосеф ах дүү нартаа өөрийгөө хэн болохыг илчилдэг. 45-р бүлгийн 2-р ишлэлд “Иосефын енгэнэн уйлсан нь египетчүүдэд сонсогдсон ба Фараоны ордонд ч сонсогджээ” гэсэн байна. Иосеф 7-р эшлэлд Бурхан “...та нарыг амь хэлтрүүлж, үр удмыг чинь газар дэлхий дээр үлдээхээр” өөрийг нь Египет рүү илгээсэн гэдгийг хэлжээ. Тэгээд ах нартаа эцэг Иаковыг нь Египетэд авчрахыг тушаав. Энэ үзэгдэл 14-15-р эшлэлээр төгсдөг бөгөөд энд Иосеф, Бениамин хоёр бие биеэ тэврэн уйлж буй сэтгэл хөдөлгөм дүр зураг гардаг. Мөн Иосеф бүх ах нараа үнсэж, тэдэнтэй ярилцаж буй тухай өгүүлдэг.

Иосефын түүхийн дунд хэсэгт Иосеф болон түүний ах нар хоорондоо эвлэрсэн тухай гардаг. Иосеф аль хэдийнээ Египетэд ирчхээд байсан бөгөөд ган гачиг ч болов. Түүний ах нар өлсгөлөнгийн улмаас хоол хүнс, тусламж хайхаар ирсэн. Харин эдгээр үйл явдлуудад буюу ялангуяа 45-р бүлэгт, Иосеф болон түүний ах нар эцэстээ эвлэрч байгаа гайхалтай зураглал гардаг. Энэ нь үнэндээ Эхлэл номын хамгийн гайхалтай, сэтгэл хөдөлгөм тэр дүр зураг билээ. Энэ хэсэгт ах дүү нар бие биеэ тэврэн уйлсаар байгааг өгүүлжээ. Энэ үед болон түүний өмнөх бүлэгт тэд маш их уйлсан тул египетчүүд хүртэл тэднийг яагаад ингэж уйлж байгаа юм бол гэж гайхсан байдаг. Энэ бол ах дүүсийн дунд хагарал гарсан байсан ч яг тэр мөчид бүрэн эвлэрч, нэгдэж байгаа гайхалтай сайхан дүр зураг юм. Энэ эв нэгдэл нь Иосеф ах нараа сорьж шалгахад, тэд үнэхээр өөрчлөгдөж, өөр болцгоосон байсныг мэдсэнээс үүдэлтэй. Ах нар нь анх аавыгаа хуурч, Иосефыг хөнөөх

гэж оролдож байсан бол одоо тэд огт өөр хүмүүс болжээ. Тэд өөрчлөгдсөн бөгөөд тэдний дундаас зарим хүн, ялангуяа Иуда нь онцгой их өөрчлөгдсөн гэдгээрээ ялгарч байв... Эвлэрэл нь ах дүүс өөрчлөгдсөнтэй, бас Иосеф ч гэсэн өөрчлөгдсөнтэй холбоотой байлаа. Иосефын хувьд зүүд болон өөр бусад зүйлээрээ ихэд бардамнаж сайрхдаг, онгиороо залуу байсан бол өдгөө эрх мэдэлтэй, энэрэнгүй хүн болж өөрчлөгдсөн байв. Энэхүү өөрчлөлтийг бид энэ бүлгээс болон үүний өмнөх бүлгүүдээс харж болно. Ах дүүсийн бие биеэ тэврэн уйлж буй энэ дүр зураг маш үнэ цэнтэй бөгөөд Мосегийн үеийн Израилчуудын зүрх сэтгэлд хадагдан үлдсэн нь лавтай.

— Др. Ричард Л. Пратт, Жр

Үүний дараа 45:16-24-д ах нараа явуулж эцэг Иаковоо авчруулахыг Фараон Иосефт тушаасан. Фараон 20-р эшлэлд “Египет нутгийн хамаг сайн сайхан юм та нарынх” хэмээн Иосефт амлаж байна. Иосеф ч Фараоны тушаалыг дагасан бөгөөд шинэхэн эв нэгдлээ хадгалахыг ах нартаа захиж байгааг 24-р эшлэл дэх “Замдаа битгий хэрэлдээрэй!” гэсэн үгээс нь харж болно.

Хоёр дахь аяллын төгсгөлд буюу 45:25-28-д ах дүүс Канаан руу буцаж ирдэг. Тэд Египетэд болсон явдлыг Иаковд хэлэхэд, тэрээр тэдэнтэй хамт Египет рүү явжээ.

Эхний болон хоёр дахь аяллаар эцгүүд эвлэрч, дахин нэгдсэн тухай бид үзээд байна. Одоо Эхлэл 46:1-47:12-т гардаг гурав дахь аяллын талаар хамтдаа харцгаая.

Гурав дахь аялал (Эхлэл 46:1–47:12)

Гурав дахь аялал нь хоёр үндсэн хэсгээс бүрддэг. Эхнийх нь 46:1-27-д гардаг бөгөөд энд ах дүүс дахин Египет рүү явж буй тухай өгүүлдэг. Гэхдээ энэ удаад Иаков тэдэнтэй хамт явсан. 1-7-р эшлэлээс бид энэ аяллын талаар төдийгүй Бурхан Иаковыг Египетэд ч гэсэн ивээх болно гэдгээ батлан хэлж байгааг харж болно. Энэ аяллын төгсгөлийн хэсэг нь 46:8-27 дахь Египет рүү явсан Иаковын хөвгүүд болон ач нарынх нь нэрсийн жагсаалтаар өндөрлөдөг.

Хоёр дахь хэсэг нь эхний болон хоёр дахь аяллын нэгэн адил 46:28-47:12-т Египетэд болсон хэд хэдэн үйл явдлын тухай өгүүлдэг. Иаков, Иосеф хоёр эргэж уулзахад Иуда гол үүрэг гүйцэтгэсэн тухай 46:28-30-д гарч байна. Дараа нь 46:31-47:12-д Фараон Иосефын гэр бүлийг хүлээн авч, Гошен хотод Иосефын халамж дор амьдрахыг тушаажээ.

Эцгүүд эвлэрч, дахин нэгдсэн тухай Мосе бичсэнийхээ дараа тус түүхийн дөрөв дэх үе шат руу буюу өрнөлөөс бууралт руу шилжиж байна. Эхлэл 47:13-27-д Иосеф Египетэд хэрхэн энэрэнгүй сэтгэлээр захирч байсан тухай өгүүлдэг.

ИОСЕФЫН ЭНЭРЭНГҮЙ ЗАХИРГАА (ЭХЛЭЛ 47:13-27)

Цаг хугацаа өнгөрөх тусам өлсгөлөн улам бүр дордсоныг 47:13-26-аас харж болно. Иосеф Египет болон Канаан даяар хоол хүнс нийлүүлэв. Мөн тэрээр египетчүүд болон канаанчуудыг хоол хүнсээр хангахын тулд тэдний мал, газар нутгийг худалдан авч, Фараоныг улам хүчирхэгжүүлжээ. Үүгээр ч зогсохгүй энэ бүх үйл явдлаар дамжуулан тэрээр тоолж баршгүй олон хүний амийг аварсан юм.

Энэ түүхийн сүүлчийн хэсэг буюу Эхлэл 47:27-д Мосе Иосефын засаглал Иаков болон түүний хөвгүүдэд хэрхэн ашиг тусаа өгснийг дурджээ. Мосе энд бичихдээ:

“Израилчууд Египет нутагт, Гошен газар нутаглан сууж, тэндээ суурьшин өсөж үржээд, үлэмж олуул болжээ” гэв (Эхлэл 47:27)

Эцгүүд анх эв нэгдэлгүй байсан тухай, мөн Иосефыг удирдагч болоход тулгарч байсан саад бэрхшээл, ах дүүсийн эвлэрэл, дахин нэгдсэн явдал, Иосефын Египет дэх энэрэнгүй засаглал зэргийг үзсэний дараа бид одоо Иосеф болон түүний ах дүү нарын тухай Мосегийн өгүүлсэн түүхийн сүүлчийн үе шатанд ирээд байна. Эхлэл 47:28-50:26-д Иосефын гэр бүл Иосефын удирдлага дор эв найртай амьдарч байгааг харж болно.

ЭЦГҮҮДИЙН ЭВ НЭГДЭЛ (ЭХЛЭЛ 47:28–50:26)

Энэ сүүлчийн алхам нь эцгүүдийн хоорондын эв нэгдэлгүй байдал болох эхний асуудал шийдэгдсэн гэдгийг харуулдаг. Мөн Иосефын гэр бүлийн эв нэгдэлд гол анхаарлаа хандуулж байгаа нь энэ эв нэгдэл Израил ерөөлийг хүртэх үндэс болсон гэдгийг харуулдаг. Энэ бүхэн Мосегийн анхны сонсогчдод онцгой ач холбогдолтой байсан нь гарцаагүй.

Эцгүүдийн эв нэгдлийн тухай өгүүлсэн эдгээр бүлэг нь үндсэн хоёр хэсэгт хуваагдана. Нэгдүгээрт, Эхлэл 47:28-50:14-т Мосе Иаковын амьдралын сүүлийн өдрүүдэд тогтсон гэр бүлийн тогтолцоонд буюу зохион байгуулалтад анхаарлаа хандуулсан байдаг. Дараа нь Эхлэл 50:15-26-аас Иосефын гэр бүлийн тогтолцоог харж болно. Эхлээд Иаковын гэр бүлийн зохион байгуулалтыг харцгаая.

Иаковын гэр бүлийн зохион байгуулалт (Эхлэл 47:28-50:41)

Энэ хэсэг Иаковын үхэх хоног ойртож байгаа тухай өгүүлж эхэлдэг. Иаков өөрийг нь Канаан нутагт оршуулна гэж ам тангараг өгөхийг Иосефоос шаардсан тухай Мосе 47:28-31-д тайлбарласан байна. Үүний дараа 48:1-49:28 дээрээс бид Иаковын ерөөлтэй холбоотой хоёр уулзалтын тухай уншдаг.

Эхний уулзалт дээр буюу 48:1-22-д Иаков Иосеф болон түүний хөвгүүд болох Ефраим, Манассе нарыг хувьчлан ерөөж байгаа тухай гардаг. Энд Иосеф ихэвчлэн ууган хүүд өгдөг давхар өвийг буюу илүү нэг хувийг хүлээж авч байгаа тухай, мөн Ефраим, Манассе хоёрыг авга ах нартай нь адил тэгш авч үзэхээр шийдсэн гэдгээ Иаков хэлдэг. Үүнээс гадна өөр нэг санаанд оромгүй зүйл болсон нь Иаков Иосефын хоёр дахь хүү Ефраимыг ууган хүү Манассегаас нь дээгүүр тавьсан явдал байв.

Иаков 49:1-28-д Иосеф болон түүний хөвгүүдийг ерөөсний дараа Иаковын бүх хөвгүүд эцгээсээ эцсийн ерөөлийг нь хүлээн авч байна. Иаков бүх хөвгүүдээ цуглуулж, амьдралд нь тохирсон байдлаар нэг нэгээр нь ерөөжээ. Иаковын эцсийн ерөөл болох энэхүү зохион байгуулалт нь ирэх үеүдэд хадгалагдан үлдэх учиртай байв.

Энэ хэсэг нь Эхлэл 49:29-50:14-өөр буюу Иаковын үхэл болон оршуулгын тухай өгүүлснээр өндөрлөдөг. Канаан нутагт оршуулаарай гэсэн эцгийнхээ хүслийг Иосеф биелүүлээд, Египет рүү буцаж ирснийг энэ хэсэгт харуулдаг.

Иосефын удирдлага доорх эцгүүдийн эв найрамдлын тухай өгүүлсэн энэ хэсэгт зөвхөн Иаковын гэр бүлийн тогтолцоог өгүүлээд зогсохгүй Эхлэл 50:15-26 дахь Иосефын гэр бүлийн зохион байгуулалтыг ч мөн өгүүлсэн байдаг.

Иосефын гэр бүлийн зохион байгуулалт (Эхлэл 50:15-26)

Энэ хэсэг нь хоёр товч хэсгээс бүрддэг. 50:15-21-д Иосеф ах дүү нартаа сайн сайхан сэтгэлээр ханддаг гэдгээ батлан хэлдэг бөгөөд Иосефын ах нар түүнээс уучлал гуйж, Иосеф ч тэднийг дуртайяа уучилсан.

Иосеф болон түүний ах нарын түүхээс бидний харж болох нэг зүйл бол өршөөл уучлалын хүч, мөн нөхцөл байдал туйлын хүнд байхад ч гэсэн Бурханы бидэнд зориулсан сайн сайхан зорилгод найдах хүч юм. Яг Иосеф шиг ийм хүнд нөхцөлд ороогүй боловч үүнтэй төстэй зүйлс хүмүүст олон тохиолддог. “Тэд намайг ийм байдалд оруулсан” гэж бид хэлж болох бөгөөд энэ нь ч үнэн байх нь элбэг. Гэвч өөрийг нь боол болгож худалдсан ах нартаа Иосефын хэлж байгаа үгсээс тэр Их Эзэнд итгэж, дуулгавартай байсан гэдгийг харж болдог. Мөн тэрээр энэ бүхнийг Бурханы өөрт нь зориулж төлөвлөсөн онцгой бөгөөд чухал зорилгын биелэл байсан гэж үзэж байгааг нь бид олж хардаг.

— Рев, Др. Майкл Волкер

Эхлэл 50:19-21-д Иосеф ах нартаа хандан:

“Битгий айцгаа. Би Бурханыг орлож яахан болох билээ? Та нар намайг хорлох гэсэн боловч Бурхан өнөөдрийнх шиг үй олон хүний амийг аврахын төлөө түүнийг сайнаар эргүүлсэн юм. Та нар одоо битгий ай. Би та нарыг болон хүүхдүүдийг чинь тэтгэнэ...” гэжээ (Эхлэл 50:19-21).

Иосеф болон түүний ах нарын тухай түүх Эхлэл 50:22-26-д Иосеф Израилын хөвгүүдээс ам тангараг авч байгаагаар өндөрлөдөг. Эхлэл 50:25-ыг харцгаая. Энд:

“Иосеф бас Израилын хөвгүүдээр тангараглуулан “Бурхан та нарт туслахаар заавал ирэх бөгөөд та нар ясыг минь эндээс авч яваарай” гэж хэлэв” гэжээ (Эхлэл 50:25).

Эхлэл номд бичсэнийг харвал энэ тангараг нь Иосеф нас барахаасаа өмнө ах дүү нартайгаа ярьсан сүүлчийн яриа байв. Бурхан Израилыг Египетээс чөлөөлөх үед Иосефын ясыг Амласан газарт аваачиж оршуулан, түүнийг хүндэлсэн хэвээр байх болно гэдгээ ах нар нь өөрсдийнхөө үр удмын өмнөөс амлаж байна.

Иосеф ах дүү нар, гэр бүлийнхэндээ хандан сүүлчийн захиас болгон “Бурхан та нарт туслахаар заавал ирэх болно. Тэр үед та нар ясыг минь эндээс авч яваарай” гэжээ. Египетийн удирдагч хүний хувьд Иосефыг нас барахад нь занданшуулж, саркофаг буюу чулуун авсанд байрлуулсан байх магадлал маш өндөр... Тэд энэ саркофагийг харах болгондоо Иосефт өгсөн амлалтыг буюу эцгүүд түүнийг амласан газар аваачих болно гэсэн амлалтыг санадаг байсан биз ээ. Иосеф “та нар ясыг минь эндээс авч явж, амласан газарт аваачиж оршуулаарай” гэж захисан. Энэ бол түүний Бурханы амлалтад итгэж найдаж байсны нэг илэрхийлэл байв... Тиймээс Иудейчүүдийг Египетээс гарахад Мосе Иосефын ясыг авч явжээ. Дахин хэлэхэд, тэр дөчин жилийн хугацаанд Иосефын яс нь амласан нутгийг Израилчуудад өгнө гэсэн Бурханы агуу амлалтын бэлгэдэл, нүдэнд харагдах сануулга болж байжээ. Тиймээс эцэст нь ясыг Шехемд оршуулсан. Зарчим нь тун энгийн. Энэ нь Бурханы амлалтууд нь амьдралын бусад бүхий л зүйлээс илүү бодитой бөгөөд Бурхан амлалтаа заавал биелүүлдэг гэдэг нь юм.

— Др. Ларри Ж. Уотерс

Өнөөг хүртэл бид Иосеф болон түүний ах нарын талаарх энэхүү хичээлээр Мосегийн өгүүлсэн түүхийн бүтэц, агуулгыг авч үзээд байна. Одоо энэ хичээлийн хоёр дахь гол хэсэгтэй буюу эдгээр бүлгийн үндсэн сэдвүүдтэй танилцъя.

ҮНДСЭН СЭДВҮҮД

Иосеф болон түүний ах нарын түүх Эхлэл номын анхны сонсогчдод бидний энд дурдаж байгаагаас хамаагүй илүү нөлөө үзүүлсэн нь гарцаагүй. Гэхдээ энэ нь орчин үед ч гэсэн чухал нөлөөтэй хэвээрээ байна. Мөн эдгээр бүлгийг анхны сонсогчдын нөхцөл байдалтай холбож авч үзвэл энд тодорхой сэдвүүд давтагдаж байгааг харж болно. Бидний авч үзэх эдгээр гол сэдэв нь Иосефын түүхийн анхны сонсогчдод зориулагдсан сэдвүүдийг бүгдийг нь хамрахгүй. Мөн энэ нь бидний өнөөдөр амьдралдаа хэрэгжүүлэх ёстой бүх арга замыг ч төлөөлөхгүй. Гэхдээ эдгээр гол сэдэв нь Эхлэл номын энэ хэсгийн хамгийн чухал шинж чанараас заримыг нь онцлон харуулах болно.

Эдгээр бүлгийн зарим гол сэдвийг бид хоёр хэлбэрээр авч үзнэ. Эхлээд Иосефын түүх болон Абрахам, Исаак, Иаков нарын түүхэн дэх нийтлэг онцлог

шинжүүдийг бид хэрхэн авч үзэж болох талаар зарим санал бодлыг ярилцах болно. Хоёрдугаарт, Иосеф болон түүний ах нарын түүхээс хоёр онцлог зүйлийг илүү нарийвчлан авч үзнэ. Ингээд эхлээд хэд хэдэн нийтлэг шинжийг авч үзье.

НИЙТЛЭГ ШИНЖҮҮД

Эхлэл номын бусад хичээл дээр үзсэнчлэн Абрахам, Исаак, Иаков нарын амьдралын түүхэн хүүрнэлд дөрвөн гол сэдэв гарч ирдэг. Эдгээр сэдэв нь мөн Иосеф болон түүний ах нарын түүхэнд ч гарч ирэх бөгөөд эдгээр нь Израилд үзүүлсэн Бурханы нигүүлсэл, Израил Бурханд үнэнч байх шаардлага, Израилыг ерөөсөн Бурханы ивээл ерөөл, Израилаар дамжуулан бусдыг ерөөсөн Бурханы ерөөл зэргийг онцолсон байдаг. Библийн энэ хэсэг дэх Израилд үзүүлсэн Бурханы нигүүлслийн тухай сэдвийг бид хэрхэн авч үзэх ёстойг одоо харцгаая.

Бурханы Израилд өгсөн нигүүлсэл

Хэдийгээр Библид Бурханы нигүүлсэл, энэрэл хайр, нинжин сэтгэл зэргийг тодорхой нэр томъёо ашиглан илэрхийлдэг боловч Иосефын түүхэнд эдгээр нэр томъёо ховорхон гардаг. Гэхдээ энэ бүлгүүдийн туршид Бурханы нигүүлсэл нь нэгэн чухал *сэдэв* болж байгааг бид олж харсан билээ. Иосефын үеийн "өмнөх ертөнц" гэж бидний нэрлэдэг үед Бурхан заримдаа Иосеф болон түүний гэр бүлд *өнгөрсөн дэх нигүүлслээ* буюу тэдний амьдарч байснаас өмнөх цаг үед үзүүлж байсан нигүүлслээ сануулдаг. Мөн эргэлтийн чухал цаг үе бүрд Бурхан Иосеф болон түүний гэр бүлд *одоогийн нигүүлслээ* үзүүлсээр байсан. Түүнчлэн Бурхан ирээдүйд болох үйл явдлуудын тухай өгүүлэхдээ Иосеф болон түүний гэр бүл ирээдүйд ч гэсэн хэзээ нэгэн цагт Түүний *ирээдүйн нигүүлслийг* дахин хүртэх болно гэдгийг амласан. Ялангуяа Амласан газарт буцаж ирэх тэрхүү нигүүлслийг хүлээн авах болно гэдгийг үргэлж хэлж байв.

Гэхдээ энэхүү гурван төрлийн нигүүлсэл нь зөвхөн Иосефын түүхээр хязгаарлагдахгүй. Мосе Иосефын ертөнцөд өгсөн Бурханы нигүүлслийн талаар бичсэнээрээ анхны сонсогчдодоо "тэдний ертөнцөд" ч гэсэн Бурханы өөрсдөд нь өгсөн олон янзын нигүүлслийн талаар бодох боломжийг олгожээ.

Үүний нэгэн адил, Христийн дагалдагчдын хувьд бид Иосеф болон түүний гэр бүлд Бурханы үзүүлсэн нигүүлслийг өөрсдийн ертөнцөд хэрэгжүүлэх боломжтой. Энэ нь олон арга замаар хэрэгжиж болох боловч үүнийг Христийн хаанчлалын гурван үе шаттай холбон авч үзэх нь ихээхэн тустай байдаг. Шинэ Гэрээний үүднээс авч үзвэл, Иосеф болон түүний ах дүү нарт Бурханы үзүүлсэн *өнгөрсөн дэх нигүүлслийг* бид Христ Өөрийн хаанчлалыг эхлүүлэхээр энэ дэлхий дээр анх ирсэнтэй холбож үзэж болох юм. Бид Иосефын түүхээс Бурханы үзүүлж буй *одоогийн нигүүлслийг* харах бүрдээ одоо ч гэсэн үргэлжилсээр байгаа Христийн хаанчлалаар дамжуулан бидний өдөр тутмын амьдралд Түүний үзүүлсээр байгаа нигүүлслийг санадаг. Мөн Иосеф болон түүний гэр бүлийнхэн Бурханы *ирээдүйн нигүүлслийг* тэсэн ядан хүлээж байсан шиг бид ч мөн адил шинэ тэнгэр, шинэ газарт

Христийн хаанчлал бүрэн төгс байгуулагдах үед бидэнд ирэх Бурханы өршөөл энэрлийг найдан хүлээдэг.

Израилд үзүүлсэн Бурханы нигүүлслийн зэрэгцээ тус түүхийн нийтлэг шинжийн нэг болох Бурханд үнэнч байх шаардлагыг Израилд тавьж байсан талаар одоо хамтдаа харцгаая.

Бурханд үнэнч Израил

Иосеф болон түүний ах дүүсийн ертөнцийн тухай Мосегийн хүүрнэл дэх хамгийн онцгой зүйлийн нэг нь Мосе энд Бурханаас өгсөн ямар нэгэн үг заавар, тушаалыг эш татаагүй явдал юм. Үүний оронд *өмнөх ертөнцөд* нь Иосеф Бурханд үнэнч байсныг Израилчууд *өөрсдийнхөө ертөнцөд* хүлээн авсан хуулиудын дагуу үнэлж цэгнэж чадна гэж Мосе найдаж байжээ.

Эцгүүд Бурханы хуульд үнэнч байснаараа авралыг олж аваагүй гэдгийг Мосе мэдэж байсан нь ойлгомжтой. Үнэндээ ингэх ямар ч боломжгүй. Гэвч тэдний дуулгавартай, бас дуулгаваргүй байсан нь уг түүхийн үе шат бүрд тэдний зүрх сэтгэлийн жинхэнэ дүр төрхийг харуулж байв. Тийм ч учраас Мосе Иосефын түүх дээр үндэслэн өөрсдийн зүрх сэтгэлийг шалгахыг сонсогчдоо уриалж байна.

Сөрөг жишээ авбал, Иосефыг алах гэсэн ах нарынх нь төлөвлөгөөг Бурхан эсэргүүцсэн тухай Мосе энд шууд ярих шаардлагагүй байв. Учир нь Гэтлэл 20:13-т гардаг хүн алж болохгүй гэсэн зургаа дахь хуулийг энэ нь зөрчиж байна гэдгийг сонсогчид аль хэдийн мэдэж байлаа. Мөн Иосефыг боол болгон худалдсан явдал нь Дэд хууль 24:7 гэх мэт хуулийг зөрчсөн хэрэг байв. Иосефын ах нар нь эцэг Иаковаа мэхлэхдээ Гэтлэл 20:12-т гардаг эцэг эхээ хүндлэх тухай зарлигийг зөрчсөн. Иуда Тамарыг биеэ үнэлэгч гэж бодоод түүнтэй унтахдаа Гэтлэл 20:14 дахь садар самуун явдлын эсрэг тушаал болон Леви 19:29 зэрэг өөр бусад хуулийг зөрчсөн хэрэг байв.

Харин илүү эерэг жишээ гэвэл, Мосе Иосеф болон түүний ах нар хэзээ Бурханд үнэнч байсныг тодорхойлохдоо Бурханы хуулийн талаарх сонсогчдын мэдлэгт бас тулгуурлаж байв. Жишээлбэл, Иосеф Потифарын эхнэрийн уруу татлагыг эсэргүүцэж, бэлгийн ёс суртахуунтай байдлыг харуулахдаа Гэтлэл 20:14 ба 17-р эшлэл дэх долоо болон аравдугаар хуулийг сахисан. Хожим нь, Эхлэл 46:29-34 зэрэг хэсэгт Иосеф болон түүний ах нар Гэтлэл 20:12 дахь тавдугаар хуулийн дагуу эцгээ хүндэлж байгааг харж болно. Ах дүүс Иосефын өмнө гэм буруугаа хүлээж, даруу болсон нь Леви 5:5-д гардаг хуулийг тусган харуулдаг. Иосефын ах дүү нартаа хандсан эелдэг, энэрэнгүй байдал нь Леви 19:18 дээрх тушаалыг үнэнчээр дагаж буй хэрэг байв. Иймээс Мосе энэхүү *өмнөх ертөнц* дэх үнэнч болон үнэнч бус байдлыг дүрслэн өгүүлэхдээ *тэдний ертөнц* дэх Израилын анхны сонсогчдынхоо үнэнч болон үнэнч бус байдалд анхаарал хандуулж байгааг бид харж болно.

Орчин үеийн Христитгэгчдийн хувьд, Бурханд үнэнч эсвэл үнэнч бус байхтай холбоотой гурван үндсэн арга замыг Иосефын түүхээс харж болно. Нэгдүгээрт, бид эдгээр жишээг Есүс Бурханд төгс дуулгавартай байсантай, ялангуяа хаанчлалаа эхлүүлэхдээ хэрхэн дуулгавартай байсантай харьцуулж, мөн эсрэгцүүлж үзэх хэрэгтэй. Хоёрдугаарт, бид Иосефын түүхийн ёс суртахууны зарчмуудыг Христийн хаанчлал үргэлжилж байгаа өнөө үед өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэхэд бэлэн

байх ёстой. Эцэст нь, Иосефын түүхэн дэх үнэнч байдлын шаардлага нь Христ дахин ирж, хаанчлалаа бүрэн төгс байгуулах тэр үед юу болох вэ гэдэг дээр бидний анхаарлыг чиглүүлэх учиртай юм. Тэр үед Христэд итгэж аврагдсан бүх хүн шинэ тэнгэр, шинэ газарт Бурханы бүрэн зөвтгөгдсөн, төгс дуулгавартай үйлчлэгч нар болон өөрчлөгдөх болно.

Одоогийн байдлаар бид Израилд үзүүлсэн Бурханы нигүүлсэл болон Бурханд үнэнч буй Израилын талаарх нийтлэг шинжүүдийг үзээд байна. Гурав дахь нийтлэг шинж буюу Иосефын түүх болон өмнөх эцгүүдийн түүхэнд аль алинд нь гардаг өөр нэг нийтлэг онцлог шинж бол Израилыг ерөөсөн Бурханы ерөөл юм.

Бурханы Израилд өгсөн ерөөл

Иосеф болон ах нарынх нь тэрхүү “өмнөх ертөнц”-ийн хувьд Бурхан эцгүүдийн үнэнч байдлыг ерөөж байсан боловч заримдаа тэдний үнэнч бус байдлыг үл харгалзан ерөөсөөр байсан гэдгийг энд дурдах нь зүйтэй юм. Мосе *тэрхүү өмнөх ертөнцөд* ард түмэндээ үзүүлсэн Бурханы ерөөлийн талаарх сэдвээ бичихдээ анхны уншигчид нь Бурхан *тэдний ертөнцөд* ч өөрсдийг нь үнэнч эсвэл үнэнч бус байхаас үл шалтгаалан тоо томшгүй олон арга замаар ерөөсөн болохыг ойлгуулахыг зорьжээ.

Иосеф болон түүний ах нарын түүхэнд гарч буй Бурханы ерөөл өнөөгийн бидний ертөнцөд ч мөн адил хамаатай. Заримдаа бид үнэнч байдлынхаа хариуд ерөөгддөг бол заримдаа бидний итгэмжгүй, үнэнч бус байдлыг үл харгалзан Бурхан ерөөсөөр байдаг юм. Христ хаанчлалыг эхлүүлэх үед Бурхан ард түмэн дээрээ ивээл ерөөлөө асгасан гэдгийг ухаарах аваас бид Иосефын түүх болон өөрсдийн амьдралын хоорондох уялдаа холбоог олж харж чадна. Түүнчлэн Христийн хаанчлал үргэлжилж буй энэ цаг үед ч гэсэн Бурхан биднийг хэрхэн ерөөж байгааг бас ойлгох болно. Үүгээр ч зогсохгүй Христийн хаанчлал бүрэн төгс байгуулагдах үед Бурхан биднийг хэрхэн ерөөхийг бид тэсэн ядан хүлээдэг юм.

Бурханы Израилд өгсөн нигүүлсэл, Израилын үнэнч байдал, Израилыг ерөөсөн Бурханы ерөөл зэрэг нийтлэг шинжийн зэрэгцээ Израилаар *дамжуулан* Бурхан бусдыг ерөөх тухай нэгэн онцлог шинжийг мөн Иосефын түүхээс бид харж болно.

Бурханы Израилаар дамжуулан өгдөг ерөөл

Бурхан Израилыг ерөөгөөд зогсохгүй Өөрийнх нь хаанчлал болон ерөөлийг бүх үндэстэнд түгээхийг Абрахам болон түүний үр удамд тушаасан гэдгийг Эхлэл 12:3, 22:18, 26:4 зэрэг эшлэлд хэлсэн байдаг. Юун түрүүнд Иосеф Египетэд байхдаа бусдад ерөөл болж байсан тэдгээр үйл явдлаас энэ сэдэв Иосефын цаг үед ч үргэлжилж байсныг харж болно. Жишээлбэл, Эхлэл 39:5-д Потифар Иосефоос болж ерөөгдөж байсан. Мөн 39:22-д түүнээс болж Фараоны шоронгийн харгалзагч ерөөгдсөн гэдгийг хэлсэн байдаг. Иосеф Фараоны зүүдний утга учрыг тайлснаараа Фараонд ч гэсэн ерөөл болсон гэдгийг 41:25-аас харж болно. Гэхдээ бусдыг ивээсэн хамгийн агуу ерөөл нь Иосеф эрх мэдлийн өндөрлөгт хүрсэн үедээ египетчүүдийг

болон бусад үндэстнийг ерөөсөн явдал байлаа. Энэ талаар Эхлэл 41:56-57-д ийн өгүүлсэн байдаг. Энд:

“Тэгээд нутаг орон даяар өлсгөлөн болж, Иосеф бүх агуулахыг нээж, египетчүүдэд худалджээ... Улс орон бүхэн үр тариа худалдаж авахын тулд Египет рүү Иосеф дээр ирэв. Учир нь дэлхий даяар бэрх өлсгөлөн болж байлаа” гэжээ (Эхлэл 41:56-57).

Израил бусдад ерөөл болох тухай энэ сэдэв Мосегийн анхны хүлээн авагчдын өөрсдийнх нь буюу "тэдний ертөнцөд" ямар хамааралтай болохыг олж харахад тийм ч хэцүү биш. Нэгдүгээрт, Эцгүүд нь аль хэдийн бусдад ивээл ерөөл болж байсан гэдгийг Иосефын түүхээс сонсох нь израилчуудад урам зориг өгч байсан болов уу. Тэд бас Бурхан ивээл ерөөлөө бусдад түгээхийн тулд өөрсдийг нь дуудсан гэдгийг ойлгосон байх. Үүгээр ч зогсохгүй үр удам нь ирээдүйд Бурханы ерөөлийг дэлхий даяар түгээх болно гэдэгт итгэж, найдаж байсан нь лавтай.

Энэ сэдэв бидний амьдарч буй ертөнцөд ч хамаатай гэж та бодож байгаа гэдэгт итгэлтэй байна. Христ хаанчлалаа эхлүүлэхдээ энэ ертөнцийг ерөөсөн. Хаанчлалын үргэлжлэх үед ч гэсэн Христ чуулганаараа дамжуулан дэлхий ертөнцийг ерөөсөөр байна. Мөн нэгэн өдөр, Түүний хаанчлал бүрэн төгс биелэх үед Тэр дэлхийн бүх овог, ард түмнийг ерөөх болно.

ОНЦЛОГ ШИНЖҮҮД

Иосефын түүхийн гол сэдвүүдийг авч үзэхдээ бид Иосефын түүх болон Эхлэл ном дахь эцгүүдийн түүхэн дэх нийтлэг шинжүүдийг судалсан билээ. Харин одоо зөвхөн Иосефын түүхэнд гардаг хоёр онцлог чанарт анхаарлаа хандуулцгаая. Энэ талаар хичээлийн эхэнд юу гэж үзсэнийг эргэн нэг харья. Энд:

Иосеф болон түүний ах дүү нарын түүх нь Амласан газрыг эзлэн авч, суурьших үедээ хэрхэн эв найртай амьдрах учиртайг Израилын овгуудад заадаг гэж хэлж болно.

Бидний үзсэнчлэн, Эхлэл номын ихэнх хэсэг нь Иосеф болон түүний ах нарын хоорондын эв нэгдэлгүй байдал болон эвлэн нэгдсэнтэй холбоотой байдаг. Иосеф болон түүний ах дүү нар бол Израилын арван хоёр овог аймгийн эцгүүд юм. Тиймээс тэдний харилцаа нь Мосегийн үеийн Израилын овгуудын хоорондын харилцаатай шууд холбоотой байв. Энэ холбоог Эхлэл 50:24-25-д гардаг Иосефын хэлсэн сүүлчийн үгсээс тодорхой харж болно. Энд:

“Иосеф ах дүү нартаа “Би үхэвч Бурхан та нарт туслахаар хүрч ирж, та нарыг энэ газраас дагуулан гаргаад, Абрахам, Исаак, Иаковт тангарагласан тэр газарт аваачна” гээд, Иосеф бас Израилын хөвгүүдээр тангараглуулан “Бурхан та нарт туслахаар заавал ирэх бөгөөд та нар ясыг минь эндээс авч яваарай” гэж хэлэв” гэжээ (Эхлэл

50:24-25).

Энэ хэсэг нь Иосефын үеийн буюу “өмнөх ертөнцийг” Мосегийн анхны сонсогчдын буюу “тэдний ертөнцтэй” холбож өгсөн гэдгийг онцлон тэмдэглэхгүй байж болохгүй. Мосе Иосеф болон түүний ах нарын түүхийг Эхлэл номын анхны сонсогчдын амьдралд тохиолдож байгаа зүйлтэй буюу тэдний Амласан газарт очиж, суурьших үйл явдалтай холбон, Иосефын ирээдүйн найдлагынх нь талаарх үгсээр өндөрлөж байна.

Иосефын сүүлчийн үг болон энэ түүхийн анхны сонсогчдын амсаж туулж байсан зүйлсийн хоорондох холбоог хэд хэдэн арга замаар нэгтгэн дүгнэж болно. Гэхдээ хичээлийнхээ зорилготой уялдуулан энд зөвхөн хоёр онцлог шинжийг нь авч үзэх гэж байна. Эхлээд бид Мосегийн үед Израилын овгуудын дундах үндэсний эв нэгдлийг дэмжих зорилгоор Иосеф болон түүний ах нарын түүх хэрхэн бүтээгдэснийг авч үзэх болно. Хоёрдугаарт, Израилын овгуудын дунд үндэстний ялгарлыг буюу овгууд хоорондоо ялгаатай байхыг Бурхан зөвшөөрсөн гэдгийг Мосе энд илэрхийлж байгааг бид судлах болно. Эхлээд үндэсний эв нэгдэл гэсэн сэдвийг авч үзье.

Үндэсний эв нэгдэл

Үндэсний эв нэгдлийн тухай энэ сэдэв ямар чухал болохыг ойлгохын тулд Иосеф болон түүний гэр бүлийн түүх Эхлэл номд дахин дахин давтагдаж гардаг нэг ижил хэв маягаас эхэлж байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Бид энэ хэв маягийг "онцгой залгамжлал" гэж нэрлэж болно. Онцгой залгамжлал гэдгээр бид Бурханы онцгой таалал нэг гол хүнээр буюу эцгүүдийн нэгээр цаг хугацааны туршид дамжаар байсан гэсэн утгыг илэрхийлж байгаа юм.

Үүнийг ингэж бодоод үзээрэй. Эхлэл 1:1-11:9 дээрх өнө эртний түүхэнд Бурхан эхлээд Адам болон түүний үр удамд бүх дэлхийг дүүргэж, захирахыг тушаасан. Тэд Бурханы сүр жавхланта хаанчлалыг дэлхий даяар түгээх ёстой байв. Гэвч гэм нүгэл дэлхийд орж ирснээр энэ амлалт Каинаар бус харин зөвхөн Сетээр дамжих болсон. Үүний дараа Бурхан Ноатай хийсэн гэрээгээ батлах хүртэл Бурханы онцгой таалал Сетийн үр удамдар дамжин үргэлжилж байв. Ноагийн хувьд Шем, Хам, Иафет гэсэн гурван хүүтэй байсан. Гэхдээ Бурханы амлалт зөвхөн Шемийн удамдар дамжих болжээ. Мөн өнө эртний түүхийн төгсгөлд Шемийн үр удам болох Абрахам Бурханы амлалтын цорын ганц өв залгамжлагч болсон юм.

Эхлэл 11:10-37:1-д гардаг эртний эцгүүдийн түүхээс энэхүү онцгой залгамжлалын хэв маяг үргэлжилж байгааг харж болно. Абрахамын амлалтууд Ишмаел болон Абрахамын бусад хөвгүүнд биш зөвхөн Исаакт л дамжсан. Мөн Исаакт өгсөн Бурханы амлалт Есавын оронд зөвхөн Иаковт дамжсан байна.

Энэхүү онцгой залгамжлалын хэв маяг Эхлэл номын эхний 36 бүлэгт маш чухал байгаа нь харагддаг боловч Иосеф болон түүний ах нарын түүхтэй хамт энэ хэв маяг гэнэт төгсгөл болдог. Эхлэл номын энэ хэсэгт Мосе “нийтийн залгамжлалыг” онцолсон. Бурханы онцгой таалал нь Иаковаас ганц хүүд нь биш, харин арван хоёр хүүд нь бүгдэд нь дамжсан гэдэгт Мосе итгэж байв. Иаковыг нас барахад түүний арван хоёр хүү болон тэдний үр удам болох Израилын арван хоёр овог аймаг Иаковын амласан газрын өвийг хамт хуваалцах болсон. Иаковын өвийг

бүх хүүд нь ингэж ижил тэнцүү хуваарилж байгаа нь Мосегийн Израил сонсогчдын дунд үндэсний эв нэгдлийг бий болгох зорилготой байв.

Бид Иаковын түүхийг, дараа нь Иосеф болон түүний ах Иудагийн түүхийг уншиж байхдаа энэ гэр бүлд маш их зөрчилдөөн, атаа жөтөө, хэрүүл маргаан байсныг, мөн Бурхан гэрээнийхээ ард түмнийг ийм байдлаар амьдрахыг хүсээгүй гэдгийг ойлгож болно. Тиймээс Иосеф, Иуда хоёр хоорондоо зөрчилдөхөө больж, хэрхэн эвлэрэн нэгдсэн тухай энэхүү түүх нь гэрээний ард түмний дотор эв нэгдлийг бий болгохын тулд Бурхан хэрхэн ажилладаг тухай парадийм загвар болж чадна гэж би бодож байна. Энэ нь хожмын хүмүүст сайн үлгэр дуурайлал болж өгдөг. Иосеф, Иуда хоёр бол Израилын хоёр томоохон овог юм. Энэ хоёр овог нь гэрээний ард түмнээс Бурханы хүсдэг тэр эв нэгдлийг харуулсан гайхалтай жишээ болдог.

— Др. Роберт Б. Чишолм, Жр

Бид өмнө нь үзсэнчлэн, Иосеф болон түүний ах нарын түүх нэг нэгнийхээ эсрэг үйлдсэн нүглийн улмаас үүдсэн зөрчилдөөнөөр эхэлдэг. Гэвч ах дүүс эвлэрч, нэгдсэнээр энэ түүх төгсдөг. Мосе энэхүү хүүрнэлээрээ дамжуулан, Бурхан Израилын овгуудыг үндэсний эв нэгдлээ хадгалахыг уриалан дууддаг гэдгийг өөрийг нь дагаж байсан бүх хүнд тодорхой харуулжээ. Иосефын түүхэнд илэрхийлсэнчлэн, Абрахам, Исаак, Иаков нарт Бурханы өгсөн Амласан газар нутгийг бүх Израил хамтдаа хуваан авч байна.

Тиймээс Мосе Израилын овгуудын эв нэгдлийн талаар өөр хэсгүүдэд ч ярьсан нь гайхах зүйл биш юм. Жишээ нь, Гэтлэл 19:8-д тэрээр Израилчууд бүгдээрээ Синаи уулан дээр Бурхантай гэрээ байгуулахыг санал нэгтэй зөвшөөрсөн гэдгийг онцолсон байдаг. Тооллого 32-р бүлэг болон Иошуа 1:12-18-д Мосе, Иошуа хоёр хоёулаа Израилын овгууд тарж суурьшихаасаа өмнө Канаан нутагт хамтдаа тулалдах ёстой гэж шаардаж байв. Мосе мөн Дэд хууль 29:2-т гэрээг шинэчлэхдээ бүх овгийг цуглуулсан тухай гардаг.

Нэмж дурдахад Израилын үндэсний эв нэгдлийг Хуучин Гэрээний хожмын үеийн зохиолчид ч гэсэн онцлон тэмдэглэсээр ирсэн. Хэдийгээр Давид, Соломон хоёр алдаа дутагдал гаргаж байсан боловч үүнийг үл харгалзан, нэгдсэн хаант улсын эрин үеийг Израилын алтан үе гэж үздэг. Израил үндэстэн Умард болон Өмнөд хаант улс болж хуваагдсан нь Бурханы ард түмэнд зориулсан туйлын зорилгод хүрэхгүй байв. Цөллөгийн дараа овгууд дахин нэгдэнэ гэсэн амлалтыг хожим нь Израилын эш үзүүлэгчид дамжуулж байлаа. 1,2-р Шастир зэрэг номуудыг харвал цөллөгийн дараа Израилын овог тус бүрийн төлөөлөгчид Амласан газарт суурьших ёстой гэж үзэж байжээ.

Мосе өөрсдийнхөө ертөнц дэх Израилын овгуудын үндэсний эв нэгдлийг дэмжихийн тулд Иосеф болон түүний ах дүүсийн ертөнц дэх арван хоёр овгийн эцгүүдийн эв нэгдлийг онцлон өгүүлсэн. Энэхүү онцлог шинж нь Иосеф болон түүний ах дүү нарын түүхийг орчин үеийн ертөнцөд хэрэгжүүлж болох гол арга замуудын нэгийг харуулдаг. Израилын овгууд нийтлэг өвийг залгамжилж авсан шиг

дэлхий даяарх Христийн бүх дагалдагчид Христ дотор нийтлэг өвийг хүлээж авсан юм. Есүс хаанчлалаа эхлүүлэхдээ энэхүү эв нэгдлийг бий болгосон. Христийн хаанчлал үргэлжилж буй энэ цаг үед бид ч гэсэн эв нэгдэлтэй байхын төлөө хичээн зүтгэх ёстой. Нэгэн өдөр Христийн хаанчлал бүрэн төгс байгуулагдахад Бурханы ард түмэн төгс эв нэгдэлтэй болж, эвлэлдэн нэгдэхийг бид баярлан харах болно. Паул Ефес 4:3-6-д юу гэж хэлснийг харцгаая. Энд:

“Амар тайвны хүлээс дотор Сүнсний нэгдлийг хадгалахыг хичээгтүн. Та нар өөрсдийнхөө дуудлагын нэг найдвар дотор дуудагдсаны адил нэг бие, нэг Сүнс, нэг Эзэн, нэг итгэл, нэг баптисм, нэг Бурхан байна. Тэр бол бүгдийн Эцэг бөгөөд бүгдийн дээр бүгдээр дамжуулан бүгдийн дотор байдаг” гэжээ (Ефес 4:3-6)

Энэ багц эшлэлийн гол утгыг авч үзэцгээе. Паул Христийн дагалдагчдыг “Сүнсний нэгдлээ хадгалахын тулд хичээгтүн” хэмээн уриалж байна. Израилын овгуудад байсан нийтлэг өвийн нэгэн адил бид ч гэсэн нэг бие, нэг Сүнс, нэг найдвар, нэг Эзэн, нэг итгэл, нэг баптисм, нэг Бурхан Эцэг гэсэн нийтлэг зүйлтэй.

Иосеф болон түүний ах нарын түүх нь өнөөгийн Христийн дагалдагчид бидний дунд байнга гардаг эв нэгдэлгүй байдлын талаар эргэцүүлэн бодох боломжийг олгодог. Энэ нь мөн дэлхий даяарх Бурханы ард түмний эв нэгдлийн төлөө өөрсдийгөө зориулахад туслах практик удирдамжийг өгдөг юм.

Иосефын түүх Израилчуудыг эв нэгдэлд уриалж чадсан шалтгаан нь Иосеф ууч сэтгэлтэй хүн байсантай холбоотой. Уучлал бол зөвхөн Израилын ард түмнийг төдийгүй Христитгэгчид, бидний гэр бүл, энэ дэлхий дээр амьдарч буй бид бүгдийг нэгтгэдэг цорын ганц зүйл юм. Ах нар нь Иосефтой үнэхээр зүй бус харилцсан боловч зовлонд унах үед нь Иосеф тэднийг аварсан... Иосефын түүхээс, түүний ах нараа хэрхэн уучилсан түүхээс бид Иосеф үнэхээр маш том зүйлийг уучилсан гэдгийг харж болно. Ах нар нь түүнийг үхлийг хүссэн. Тэд түүнийг амьд байлгахыг хүсээгүй. Бас тэд түүнтэй дахиж уулзахыг хүсээгүй. Гэвч Иосеф тэднийг хорлохыг хүсээгүй. Түүнд хариугаа авах эрх мэдэл, нөлөө байсан хэдий ч ах нараасаа илүү сүсэг бишрэлтэй, итгэл үнэмшлээрээ илүү төлөвшсөн нэгэн байсан тул тэдэнтэй эвлэрсэн. Энэ явдал Израилын арван хоёр овогт давтагдах боломжтой байсан төдийгүй бидний дотор, гэр бүл, сүм чуулган, нийгэмд ч давтагдах боломжтой юм.

- Рев, Др Киприйн К. Гучиенда

Моше Израил үндэстний эв нэгдлийг онцгойлон дэмжиж байсан гэдгийг ойлгох нь чухал боловч Моше яагаад ингэх болсныг ойлгох нь бас чухал юм. Товчоор хэлэхэд, Бурхан Өөрийн ард түмэнд бас үндэстний хувьд ялгаатай байхыг тушаасан учраас Мосегийн хувьд энэ ялгарал дунд эв нэгдэлтэй байх хэрэгтэй гэдгийг онцолжээ.

Үндэстний ялгаа

Энгийнээр хэлбэл, овгийн эцгүүд бүгдээрээ Иаковын өв залгамжлагчид байсан боловч энэ нь тэдэнд бүгдэд нь адил тэгш хандсан гэсэн үг биш юм. Харин ч эсрэгээрээ, Бурхан Израилын овгуудад өөр өөр эрх ямба, үүрэг хариуцлагыг өгсөн гэдгийг Хуучин Гэрээний бусад хэсэгт тодорхой харуулдаг. Мосе нэг чухал шалтгааны улмаас Израилын овгууд эв нэгдэлтэй байх шаардлагатайг онцолж байсан. Энэ бол Бурхан *Өөрөө* овог тус бүрд ялгаатай эрх ямба, үүрэг хариуцлагыг өгсөн гэдгийг Израилчууд хүлээн зөвшөөрөх явдал байв. Зөвхөн энэ тохиолдолд л Израил эв нэгдлээ хадгалах боломжтой байлаа.

Иосеф болон түүний ах дүү нарын түүхийн алхам бүрд эв нэгдлийн тухай гардаг шиг, ялгаатай байдлын тухай энэ сэдэв ч бас илэрхийлэгдсээр ирсэн. Үүнийг ялангуяа Эхлэл 47:28-49:33-аас тодорхой харж болно. Энэ бүлэгт Иаков арван хоёр хүүдээ бүгдэд нь өв хөрөнгөө хуваасан ч хүн бүрд болон тэдний үр удамд мөнхийн ялгааг бий болгосон.

Эдгээр бүлэгт Мосе Иаковын хөвгүүдийг бүгдийг нь ялгаатай байдлаар илэрхийлж, үүгээрээ дамжуулан Израилын овгуудын дундах ялгааг тодотгож өгч байна. Гэхдээ бид хичээлийнхээ зорилготой уялдуулан энд зөвхөн хоёр гэр бүлийг буюу Иуда ба түүний үр удам, Иосеф ба түүний үр удмын талаар авч үзэх болно. Юуны өмнө Иуда болон түүний үр удамд өгөгдсөн нэр хүндийг авч үзэцгээе.

Иуда ба түүний үр удам. Эдгээр бүлэгт Мосе Иудаг хэд хэдэн удаа гол дүр болгож онцлон өгүүлсэн нь Бурхан Иуда болон түүний овгийг онцгойлон томилсон байсан гэдгийг баталж байна. Иудагийн талаар анхлан Эхлэл 37:12-36-д гардаг бөгөөд энд ах нар нь Иосефыг алах гэж байсан тухай өгүүлдэг. 26-27-р эшлэлд Иуда ах дүүсийнхээ дундаас ялгаран, Иосефыг хамгаалж үг хэлсэн бөгөөд энэ нь ч амжилттай болсон. Иуда 27-р эшлэлд “Тэр [Иосеф] бол бидний дүү, мах цусны маань тасархай” хэмээн сануулж, эв нэгдэл бол ах дүүсийн онцлог байх ёстой гэдгийг батлан хэлж байна. Энд ах дүүс нь түүний төлөвлөгөөг зөвшөөрч байгаа нь тэд Иудагийн удирдлагыг хүлээн зөвшөөрдөг байсан гэдгийг харуулдаг.

Иуда 38:1-30-д дахин гардаг бөгөөд Мосе энд Канаан нутаг дахь Иудагийн гэм нүглийн түүхийг өгүүлжээ. Энэ бүлэгт Иудагийн ёс суртахуунгүй байдлыг Потифарын гэрт байсан Иосефын үнэнч шударга зантай харьцуулж харуулдаг. Гэхдээ Иуда “Тэр [Тамар] надаас илүү зөв юм байна” хэмээн даруугаар буруугаа хүлээн зөвшөөрч байгааг Мосе 38:26-д өгүүлж байна. Бурхан Иудаг Перез, Зера гэдэг ихэр хүүтэй болгож ерөөснийг харвал Иудагийн гэмшлийг хүлээн авсан нь тодорхой байна.

Мосе 44:14-34-т эцгүүдийн Египет рүү явсан хоёр дахь аяллын үеэр Иудагийн манлайллыг дахин онцлон харуулсан байдаг. Бениаминыг мөнгөн аяга хулгайлсан гэж хилсээр буруутгах үед Иуда Иосеф дээр очиж, өршөөл гуйсан. Тэрээр энд өөрийгөө болон ах дүүсээ Иосефын “зарц” гэж нэрлэж байна. Иуда ах дүү нарынхаа хамт хийсэн зүйлдээ гэмшиж, “таны зарц нарын хилэнцийг Бурхан олсон” гэж буруугаа хүлээжээ. Хэрэв Бениамин Канаан руу буцаж ирэхгүй бол эцэгт нь “гай

зовлон” ирэх болно гэдгийг хэлж, эцгээ хүндэтгэдэг болохоо харуулсан. Тэгээд “хүүгийн өмнөөс” Египетэд үлдэхийг зоригтойгоор санал болгодог.

Эцэст нь, 49:1-28-д Иаковын эцсийн ерөөлийн үеэр Иуда дахин цойлон гарч ирдэг. Иаков 8-12-р эшлэлд Иудад болон түүний овогт удирдагчийн хэзээ ч үл тасрах байр суурь өгөгдөнө гэдгийг тунхагласан. Тийнхүү Иуда овог хэзээ нэгэн цагт Израилын хааны овог болно. Эхлэл 49:8-10-д Иаковын хэлсэн ерөөлийг харцгаая. Энд:

“Иуда! Чамайг ах дүү нар чинь магтан өргөмжлөх болно. Гар чинь дайсныхаа хоолойг багалзуурдах болно. Эцгийн чинь хөвгүүд чиний өмнө сөгдөн бөхийх болно... Шилог иртэл хааны таяг Иудагаас салахгүй. Захирагчийн шийдэм түүний хөлийн хоорондоос салахгүй. Бүх хүн түүнийг дуулгавартай дагах болно” гэжээ (Эхлэл 49:8-10).

Энд Иудад хандан “чамайг ах дүү нар чинь магтан өргөмжлөх болно” гэснийг анзаараарай. Тэрээр “дайсныхаа хоолойг багалзуурдах” бөгөөд энэ нь өөрийг нь эсэргүүцэгч бүгдийг ялна гэсэн утгатай. Мөн Иудагийн “эцгийн хөвгүүд” буюу ах нар нь “түүний өмнө сөгдөн бөхийх болно.” Өмнө өгүүлсэн зүйлс дээрээ нэмээд Мосе энд Иудагийн овог Израилын бусад овгийг захирах болно гэсэн санааг илэрхийлж байна.

Иудагийн үр удам хааны бэлгэ тэмдэг болох “хааны таяг”, “захирагчийн шийдэм”-ийг барих болно гэж хэлснийг онцлон тэмдэглэх нь зүйтэй юм. Иудагийн хааны гэр бүл “бүх хүн түүнийг дуулгавартай дагах” хүртэл үргэлжлүүлэн захирсаар байх болно.

Эхлэл 49:10-д Иудагийн үр удам бүх дэлхийн хаан болно гэдгийг Библид анх удаа тодорхой дурдсан байдаг. Энэ бол Давидын удмын Мессиагийн тухай өгүүлсэн маш тодорхой эшлэл юм. Эхлэл 12:3-т Абрахамд хандан “Газар дэлхийн бүх овог чамаар ерөөгдөх болно” гэж хэлсэн Бурханы амлалтыг ирээдүйн энэ Хаан биелүүлэх болно. Энэ Хаанаар дамжуулан Бурханы хаанчлал дэлхий даяар өргөжих болно. Тийнхүү Иудагийн энэ агуу Хааныг “бүх үндэстэн дуулгавартай дагах болно.”

Мосе өөрийнхөө ертөнцийн анхны сонсогчдоо Иудагийн нэр хүндийг ингэж өргөмжилж байгаагийн учрыг ойлгоход тийм ч хэцүү биш. Иуда Иаковын ууган хүү биш байсан тул ердийн үед ийм чухал байр суурийг эзлэх боломжгүй байв. Тиймээс Мосе үндэстнийхээ эв нэгдлийг дэмжихийн тулд Иосеф болон түүний ах дүү нарын тухай ийн бичихдээ Бурхан Өөрөө Иудагийн овгийг ингэж өргөмжилсөн гэдгийг ойлгох нь үндэсний эв нэгдлээ хадгалахад тус болно гэж найдаж байсан бололтой.

Иудаг ингэж чухал байр сууринд өргөмжилсөн нь орчин үеийн Христийн дагалдагчдад ч бас олон талын ач холбогдолтой. Гэхдээ хамгийн гол нь Бурхан Иуда овгоос нэгэн хамгийн дээд Хаан гарах болно гэж амласан явдал юм. Мөн энэ амлалт Давидын төгс зөвт Хүү, орчлон ертөнцийн Хаан Есүсээр биелсэн билээ. Есүс хаанчлалаа эхлүүлж, тэнгэрт хаан сэнтийд заларсан. Түүний хаанчлал үргэлжилж, бүх дайснууд нь Түүний хөл дор орох хүртэл Тэрээр хаанчлах болно. Тийнхүү хаанчлал нь төгс байгуулагдах тэр үед Христ шинэ бүтээлийг үүрд мөнх захирах болно.

Моше Израил үндэстэн дэх ялгаатай байдлыг харуулахдаа Иуда болон түүний үр удмыг онцолсон гэдгийг бид үзлээ. Харин одоо бид Эхлэл номын энэ хэсэгт Иосеф болон түүний удмынхан хэрхэн гол байр суурийг эзэлж байгааг харцгаая.

Иосеф ба түүний үр удам. Бидний үзсэнчлэн Эхлэл 37:2-50:26-д гардаг гол дүр бол Иосеф юм. Гэхдээ бусад ах нараасаа ялгаатай нь Иосефыг энэ бүлэгт өв тэгш нэгэн мэтээр дүрсэлсэн байдаг. Үнэндээ Моше түүхийн зөвхөн эхэн хэсэгт л Иосефын зан чанарын дутагдлын талаар битүүхэн дурдсан байдаг. Иосеф ах нарынхаа дургүйг хүргэж байсныг 37:2-11-ээс харж болно. Тэрээр аавдаа ах нарынхаа тухай базаахгүй мэдээ дуулгаж, ирээдүйн тухай зүүдээ бардамнаж сайрхан ярьж байв. Гэхдээ энэ сөрөг зан чанарыг нь ч гэсэн бараг анзаарагдамгүй байдлаар илэрхийлсэн байдаг. Түүнчлэн Моше 2-р эшлэлд Иосефыг дөнгөж “арван долоон настай” гэж хэлж байгаа нь ч гэсэн энэ сөрөг зан авирыг нь хаацайлж буй хэрэг юм.

Энд цухас харагдаад өнгөрдөг сөрөг байдлыг эс тооцвол Иосефын талаарх зураглал бүхэлдээ маш эерэг байдаг. Иосеф Потифарт үнэнчээр үйлчилж, Потифарын эхнэрийн уруу татлагыг эсэргүүцсэн. Түүнчлэн Фараонд үйлчлэхдээ ч гэм зэмгүй байв. Ах нараа өөр дээр нь ирэхэд тун ухаалаг байдлаар шалгасан. Ах нар нь өөрт нь муу зүйл хийсэн ч гэсэн тэр тэдэнд эелдэг зөөлөн хандаж байв. Тэрээр аав, Бениамин хоёртоо ямар их хайртай нь харагдаж байлаа. Египетийн удирдагчийн хувьд тэрээр олон үндэстэнд ерөөл болсон. Эдгээр болон өөр олон арга замаар Моше Иосефыг Эхлэл 49:26-д “ах дүүсийнхээ дундаас тодрон гарагч” гэж Иаковын хэлсэнтэй адилхан дүрсэлсэн байдаг.

Бодит байдал дээр Иосеф амьдралдаа олон удаа гэм нүгэл үйлдсэн байж таарна гэдгийг бид бүгд туршлагаасаа мэднэ. Энэ үнэн Есүсээс бусад бүх цаг үеийн, бүх хүнд хамаатай. Тэгвэл Моше яагаад Иосефыг ингэж өв тэгш хүн мэт дүрсэлсэн бэ? Түүний зорилго юу байсан бэ? Үүнд Бурхан Иосеф болон түүний үр удамд Израилын овгуудын дунд онцгой байр суурь, нэр хүндийг өгсөн учраас гэж хариулж болно.

Эхлэл 48:1-22-д Иаков анх хөвгүүдэд нь тусгайлан хандаж байгаагаас Иосеф болон түүний удмынхны онцгой байр суурийг харж болно. Энэ эшлэлд Иаков Иосефын хөвгүүд болох Ефраим, Манассе нарыг өөрийн хөвгүүд мэт ерөөж байна. Шастирын дээд 5:1-д бичсэнээр, Реубен эцгийнхээ орыг бузарласан тул ууган хүүгийн эрхээ алджээ. Тиймээс Иаков Ефраим, Манассе хоёрыг өөрийн хөвгүүд болгон өргөж авсан нь Иосефт Иаковын ууган хүү байх эрхийг буюу давхар хувийг өгсөн гэсэн үг юм.

Энэхүү шинэ зохион байгуулалтын хамгийн сонирхолтой хэсгийн нэг бол 48:13-20-д Иаков Иосефын ууган хүү Манассег биш, харин Ефраимыг ерөөсөн явдал байв. Иосеф хөвгүүдээ Иаковын өмнө ерөөлгөхөөр суулгахдаа Иаковын баруун гар буюу илүү их ерөөлийг дамжуулах гарыг Манассегийн толгой дээр тавиулахаар суулгажээ. Ингэснээр Иаков зүүн гараа буюу арай бага ерөөлийг өгөх гараа Ефраимын толгой дээр тавих учиртай байлаа. Манассе бол Иосефын ууган хүү байсан тул ингэх нь тохиромжтой санагдахаар байв. Гэтэл Иаков ямар ч тайлбар хэлэлгүйгээр гараа зөрүүлж, зүүн гараа Манассе руу, баруун гараа Ефраим руу явуулжээ. Иосеф үүнд дургүйцэж, ууган хүү Манассе дээр Иаковын баруун гарыг тавихыг оролддог. Гэтэл чухам юу болсныг Эхлэл 48:19-дээрээс сонсоцгооё. Энд:

“Эцэг нь татгалзаж “Би мэдэж байна, хүү минь. Би мэдэж байна. Тэр [Манассе] бас нэгэн овог болж, агуу их болно. Харин дүү [Ефраим] нь түүнээс ч илүү агуу их болж, үр удам нь олон үндэстэн болно гэж хэлэв” гэжээ (Эхлэл 48:19).

Үүнийг бас “тэд бүхэлдээ нэг том үндэстэн болно” гэсэн утгаар ойлгож болно. Тооллого 2:18-21, Дэд хууль 33:17 зэрэг эшлэлд Ефраим хүн амын хувьд Манассегаас илүү олширч, нэр хүндтэй болсон гэдгийг хэлсэн байдаг. Үнэн хэрэгтээ Ефраим маш хүчирхэг байсан учраас хожим хуваагдсан хаант улсын үед Израилын хойд хэсгийг бүхэлд нь “Ефраим” гэж нэрлэх болжээ.

Энэ бүхэн орчин үеийн Христийн дагалдагчдад хамаагүй мэт санагдаж болох юм. Гэвч Иосеф болон түүний ах дүүсийн ертөнцөд Ефраим ингэж гэнэт онцгой байр суурь эзлэх болсон нь Бурханы бий болгосон тогтолцоо байсан гэдгийг Мосегийн анхны сонсогчид ойлгох нь маш чухал байлаа. Мосе Эхлэл номыг бичиж байх үед үндэстний удирдлагыг дагалдагч Иошуадаа шилжүүлэх гэж байв. Гэтэл Иошуагийн хувьд Мосе эсвэл Аарон шиг Леви овгийн хүн биш байлаа. Түүнчлэн Иудагийн хааны овгийн хүн ч байгаагүй. Гэхдээ Иошуа бол Бурханы бусад бүх овгоос илүүгээр онцлон ерөөсөн Ефраим овгийн хүн байв. Чухамдаа Мосе энэхүү хүүрнэлдээ Ефраимыг онцолж харуулсан нь залгамжлагчаа энэ овгоос сонгох болсон нэг шалтгааныг нь харуулж байна. Иошуа нас барсны дараа л Иуда овгийн нэр хүнд илүү нэмэгдэж эхэлжээ. Ефраим хүн Иошуа үндэстнийг бүхэлд нь удирдан Амласан газар руу явсан юм.

Христийн өнөөгийн дагалдагчдын хувьд Иосеф болон ах дүүсийнх нь түүхийн энэ хэсэг Бурханы энэ дэлхий дээр бидэнд өгсөн олон янзын ивээл ерөөл, үүрэг хариуцлагыг ойлгоход тусалдаг. Есүс хаанчлалаа эхлүүлэхдээ ард түмэндээ янз бүрийн бэлгүүдийг ерөөл болгон өгсөн. Тэр заримд нь элч, заримд нь эш үзүүлэгч, багш зэрэг өөр өөр үйлчлэлийг өгсөн юм. Есүс өөр өөр хүмүүсийг өөр өөр үүрэг, давуу эрхтэй байхаар дуудсан. Христ ард түмнээ хагалж бутаргахын тулд бус харин нэгтгэхийн тулд энэхүү ялгаатай байдлыг бий болгосон юм. Христийн хаанчлал үргэлжилж буй энэ цаг үед Ариун Сүнс Өөрийн хүслийн дагуу бэлгүүдээ итгэгчдэд өгсөөр байна. Тэр ч байтугай, Христийг дахин ирэх үед Христийг дагаж байсан хүмүүсийг Бурхан олон өөр арга замаар алдаршуулахыг бид харах болно. Бурхан бүхий л цаг үед ард түмнийхээ дунд ялгарлыг бий болгож өгсөн гэдгийг хүлээн зөвшөөрөхөд, мөн үүний үнэ цэнийг ойлгоход Иосеф болон түүний ах дүүсийн түүх бидэнд тусалдаг юм.

ДҮГНЭЛТ

Иосеф болон түүний ах дүүсийн тухай энэ хичээлээр бид Эхлэл номын сүүлчийн гол хэсгийн бүтэц, агуулгыг судалсан билээ. Бид мөн Мосе Эхлэл номын эхний хэсэгт гарсан гол сэдвүүдийг бататгахын тулд эдгээр бүлгийг хэрхэн ашигласан тухай, мөн энэ хэсэгт Израилчуудын эв нэгдэл, ялгаатай байдлыг хэрхэн онцлон харуулсан болохыг үзлээ.

Иосеф болон түүний ах дүүсийн энэ түүх Израилын эцгүүд бие биетэйгээ эв найртай амьдрахад хэчнээн хэцүү байсныг харуулдаг. Гэвч эцэст нь Бурхан тэдний хооронд бат бэх хайрын холбоог бий болгосон. Эв нэгдэлгүй байсны эцэст дахин эвлэрч, нэгдэн нийлсэн тухай энэхүү түүхийг анх Израилын арван хоёр овгийг гэмшилд дуудах, Бурханы ард түмний хувьд хоорондоо эвлэн нэгдэхэд уриалахын тулд бичсэн юм. Түүнчлэн өнөөдөр Христийн дагалдагчид бидний дунд байдаг аливаа хуваагдлын эсрэг байж, хайрын холбоог дэмжихийг энэ түүх уриалж байна. Христийн биеийн хувьд бид Христийн өвийг хуваалцах ёстой. Мөн Иосеф болон түүний ах дүүсийн энэхүү түүх нь бид өнөөдөр дэлхий даяарх Бурханы сүр жавхлант хаанчлалын төлөө, Бурханы ард түмний эв нэгдлийн төлөө өөрсдийгөө хэрхэн зориулах ёстойг харуулсан чухал удирдамж болдог.

ХАМТРАГЧИД

Др. Скот Рэд (Хөглөгч) бол Вашингтон Д.С дэх Шинэчлэлийн Теологийн Сургуулийн Ерөнхийлөгч, Хуучин Гэрээний Дэд Профессор. Др. Рэд нь M.Div. зэргээ Шинэчлэлийн Теологийн Сургуулиас авсан. М.А болон Ph.D зэргээ АНУ-ын Католик Их Сургуулиас авсан. Тэрээр мөн Малта дахь АНУ Католик Их Сургууль, Августин Теологийн Институти болон Газар дундын тэнгисийн Олон Улсын Сургалтын Хүрээлэнд багшилж байсан. Др. Рэд нь олон төрлийн ном зохиолыг хамтран бичсэн. Үүнд: *Tabletalk* (Ligonier Ministries), *The Washington Post* болон *First Things*. Түүнчлэн тэрээр *Constituent Postponement in Biblical Hebrew Verse* (Society of Biblical Literature, 2014) болон *Wholehearted: A Biblical Look at the Greatest Commandment and Personal Wealth* (Institute for Faith, Work & Economics, 2016) зэрэг номуудыг бичсэн.

Др. Стефан Ж. Брамер бол Далласын Теологийн Сургуулийн Библи Тайллын тэнхимийн захирал, профессор

Др. Роберт Б. Чишолм, Жр. бол Далласын Теологийн Сургуулийн тэнхимийн захирал, Хуучин Гэрээний профессор

Рев. Др. Сиприан К. Гучиенда бол Техас мужийн Даллас дахь Хайя Ланд Парк Бүх Үндэстний просбитериан чуулганы пастор

Др. бага. Ричард Л. Прагт бол Гурав дахь мянган үйлчлэлийн хамтран үүсгэн байгуулагч, ерөнхийлөгч, Шинэчлэлийн Теологийн Сургуульд Хуучин Гэрээний профессор

Рев. Др. Майкл Вокер бол Техас мужийн Даллас дахь Хайя Ланд Парк Бүх Үндэстний просбитериан чуулганы туслах теологич

Др. Ларри Ж. Вотерс Далласын Теологийн Сургуулийн Библи Тайллын тэнхимийн профессор

ҮГСИЙН ТАЙЛБАР

хиасм/хиастик – үндсэн хэсгийн өмнө болон хойно байрлах хэсгүүд нь хоорондоо зэрэгцсэн эсвэл харилцан тэнцвэртэй байдаг уран зохиолын бүтэц

Ефраим – Иосефын хоёр дахь хүү, Ах Манасегаасаа ч илүү их ерөөлийг хүлээж авсан нэгэн, мөн Иошуагийн өвөг эцэг

Израил – "Бурхан тэмцдэг" эсвэл "Бурхан тулалддаг" гэсэн утгатай Еврей үг. Энэ нь тэнгэрэлчтэй барилдсаных нь дараа Иаковт өгсөн шинэ нэр бөгөөд мөн Иаковоос бий болсон үндэстнийг хэлдэг

Израил хүн – Израил үндэстний хүн

Манасе – Иосефын ууган хүү

Потифар – Иосефыг боол болгож зарсны дараа түүнийг худалдаж авсан Египетийн цэргийн захирагч, Потифарын эхнэр Иосефыг уруу татах гэж оролдсон боловч бүтээгүй

Тамар – Иудагийн хөвгүүдийн бэлэвсэн эхнэр, Иуда түүнийг бага хүүтэйгээ гэрлүүлэхээс цааргалж байсан учир Тамар түүнийг хуурч, унтсан. Перез, Зера хоёрын ээж.

Өмнөх ертөнц – Библийг бичээчдийн түүхийг нь бичиж буй дэлхий ертөнц

Тэдний ертөнц – Бичвэрийн уншигчдын амьдарч байгаа цаг хугацаа, дэлхий ертөнц